

**ЛЭНДМН ББСБ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН
КОМПАНИУД**

(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгж)

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд
2025 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА

Ерөнхий мэлээлэл	1
Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3
Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	8
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	9
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	11

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

1	Компанийн талаарх мэдээлэл	13
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд	14
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд	25
4	Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд	25
5	Хүү болон түүнтэй адилтгах орлого ба сегментчлэлийн мэдээлэл	26
6	Хүлээгдэж буй зээлийн эрсдлийн сангийн зардал	26
7	Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал	27
8	Бусад орлого/(зардал), цэвэр	27
9	Орлогын албан татвар	27
10	Нэгж хувьцаанд ногдох ашиг	29
11	Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	30
12	Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	30
13	Санхүүгийн хэрэглүүр	33
14	Бусад хөрөнгө	33
15	Биет бус хөрөнгө	34
16	Үндсэн хөрөнгө	35
17	Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр	36
18	Зээлээр авсан санхүүжилт	36
19	Бусад өр төлбөр	38
20	Хувьцаат капитал ба бусад нөөц	39
21	Болзошгүй өр төлбөр ба үүрэг	46
22	Капитал удирдлага	47
23	Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ	47
24	Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ	50
25	Тайлант хугацааны дараах үйл явдлууд	51
26	Монгол хэл дээрх орчуулга	51

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:	О. Болдбаатар
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:	Б. Хос-Эрдэнэ Кацухико Мадоно. Ц. Ууганбаяр Ц. Одмаа. С. Энх-Амгалан
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд:	С. Боргил Ж. Жаргалсүрэн С. Нэргүй
Абан ёсны хаяг:	Сөүлийн гудамж 13А, Алтан жолоо Тауэр Сүхбаатар дүүрэг, 3-р хороо Улаанбаатар, Монгол
Харилцагч банкууд:	Хаан банк ХК Төрийн банк ХК Голомт банк ХК Хас банк ХК Худалдаа хөгжлийн банк ХК Капитрон банк ХХК Тээвэр хөгжлийн банк М Банк хаалттай ХК Ариг банк ХХК
Аудитор:	Эрнст Энд Янг Монголия Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ЛэндМН ББСБ ХК (цаашид “Компани” гэх) болон түүний охин компаниудын (цаашид хамтад нь “Групп” гэх) Гүйцэтгэх захирал Цэрэндорж овогтой Ууганбаяр, компанийн ерөнхий нягтлан бодогч Чулуунбатын Саруултуяа бид энэхүү санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компаний санхүүгийн байдал болон мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.



Цэрэндоржийн Ууганбаяр

Гүйцэтгэх захирал

Чулуунбатын Саруултуяа

Ерөнхий нягтлан бодогч

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2026 оны 2 дугаар сарын 6



Shape the future
with confidence

Ernst & Young Mongolia Audit LLC
15/F, Altan Joloo Tower
Seoul Street 13/A
Ulaanbaatar 14252
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид ЛэндМН ББСБ ХК ("Компани") болон түүний охин компаниуд (хамтад нь "Групп" гэх) -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр дурдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл ("ОУНББСЗ")-өөс баталж гаргасан СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Группээс хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудлыг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт	
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлыг Группийн удирдлага нь тодорхой хэмжээний мэргэжлийн үнэлэмж ашиглан, өндөр түвшний төсөөлөлд үндэслэн тооцдог. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн нийт хөрөнгийн 90.5 хувиас дээш хувийг бүрдүүлдэг тул тэдгээртэй холбогдох тооцооллын тодорхойгүй байдал нь өндөр гэж бид үзсэн. Иймээс зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын үнэлгээг бид аудитын гол асуудал гэж үзсэн. Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйг таамагласан Хүлээгдэж буй зээлийн алдагдлын ("ХБЗА") загварт үндэслэдэг. ХБЗА загварын тодорхой элементүүдэд удирдлагаас мэдэгдэхүйц хэмжээний тооцоолол болон таамаглал гаргах шаардлага тулгардаг. Үүнд дараах зүйлс багтана: • Санхүүгийн хөрөнгийн шатлал; • ЗҮЦХА-ын загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Төлбөр төлөгдөхгүй байх магадлал ("ТТБМ") болон Алдагдал үүсэх магадлал ("АҮМ")-ийг сонгох; • Чанаргүйдэлд Өртөх Дүн ("ЧӨД") болон ашиглагдаагүй зээлийн үүргийн хөрвүүлэлтийн коэффициентийг тодорхойлох; • ЗҮЦХА-ын загварт оруулах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлохын тулд ирээдүйн макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох, мөн тэдгээрийг магадлалаар нь жинлэх; болон • Ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоход хэрэглэсэн олон төрлийн төсөөлөл болон хүчин зүйлс дээр суурилан тусгайлан үнэлсэн зээлүүдийн үнэ цэнийн бууралтын санг тооцоолох. • Барьцааны зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох.	2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны хүлээгдэж буй зээлийн эрсдлийн санг үнэлэхтэй холбоотойгоор бидний аудитын ажиллагаа нь Группийн ХБЗА загварт ашигласан арга зүй, өгөгдөл, төсөөллүүдийг үнэлэх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Арга зүйг үнэлэхдээ бид группийн ХБЗА-ын загвар болон ашигласан арга зүй, таамаглалын удирдлагын үндэслэлийн талаарх ойлголтыг авч, загварын үндэслэлтэй байдлыг үнэлж, салбарын жишигтэй харьцуулсан. Түүнчлэн бид ашигласан таамаглалуудын үндэслэлтэй байдал, шатлалын ангиллын үндэслэл, ТТБМ, АҮМ болон ЧӨД-г тодорхойлох оновчтой байдал, загварт тусгагдсан макро эдийн засгийн хэтийн хувьсагчдыг авч үзсэн. Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээлэл, харилцагчдад оноосон зээлжих зэрэглэлийг анхны хүлээн зөвшөөрсөн өдрөөр болон санхүүгийн тайлангийн өдрөөр тус тус шалгасан. Бид мөн насжилтын тайлангийн дүнг санхүүгийн бүртгэлд тусгасан дүнтэй тулгах замаар насжилтын тайлангийн иж бүрэн байдлыг шалгаж, санамсаргүй түүврийн аргаар насжилтын тайлангийн мэдээллүүдийг холбогдох баримтуудтай тулгах замаар насжилтын тайлангийн үнэн зөв байдлыг шалгасан. Бид ХБЗА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Группийн боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний хяналтын горимд дараах ажлууд багтсан. Үүнд:



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт	
Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 2 болон 4-д тус тус толилуулсан.	- Түүхэн ТТБМ, АҮМ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээллүүдийн зөв зохистой байдлыг санамсаргүй түүврийн аргаар шалгасан; - Макро эдийн засгийн хэмжүүрүүдийг боломжит гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; - ЧӨД болон зээлийн хөрвүүлэлтийн коэффициентүүдийн хүлээлтийн үнэн зөв байдлыг шалгасан;
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаатай хамааралтай бусад толилуулга болон зээлийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн тайлангийн Тодруулга 6, 12 болон 21.3-д тус тус толилуулсан.	Бид ХБЗА-ын загварын гол өгөгдлүүдэд ашигласан үнэлэмжийн тууштай байдлыг авч үзсэн. Мөн бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн.

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл ("Бусад хэсэг") багтана.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд эсхүл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсхүл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Жилийн тайлангийн "Бусад хэсэг"-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага (Үргэлжлэл)

Компанийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Группийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсхүл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Группийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт гаргахын тулд Группд хамаарах хуулийн этгээдүүд болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлд холбогдох хангалттай, зохистой аудитын нотолгоог цуглуулах болон группийн аудитын төлөвлөлт, удирдлага, хяналт болон аудитын ажиллагааг гүйцэтгэх бүрэн хариуцлагыг хүлээдэг. Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан аудиторын дүгнэлтэд бид бүрэн хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдэд мэдэгддэг.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглал хариуцсан этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын онцгойлсон асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсхүл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээллэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Группийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Доржбатын Мандахбаяр
Партнер

Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2026 оны 2 дугаар сарын 6

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компаниуд
2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тод.	2025 Мян.төг	2024 Мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	5	135,403,123	89,190,036
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(37,018,895)	(22,181,544)
Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого		98,384,228	67,008,492
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал	6	(31,629,363)	(8,198,662)
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын дараах хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого		66,754,865	58,809,830
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	7	(17,051,092)	(12,318,753)
Бусад зардал, цэвэр	8	(739,570)	(363,817)
Татварын өмнөх ашиг		48,964,203	46,127,260
Орлогын албан татварын зардал	9.1	(8,885,261)	(10,013,611)
Нийт бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх тайлант жилийн цэвэр ашиг		40,078,942	36,113,649
		Мян.төг	Мян.төг
Нэгж хувьцаанд ногдох ашиг			
Компанийн хувьцаа эзэмшигчдийн			
Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг	10	54.21	48.85

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компаниуд
2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

	Тод.	2025 Мян.төг	2024 Мян.төг
ХӨРӨНГӨ			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	11	16,315,217	12,706,074
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	12	307,709,881	231,727,567
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө			
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	13.1	1,339,627	1,094,548
Үүсмэл санхүүгийн хэрэгслүүд	13.2	612,210	—
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө		33,000	—
Орлогын албан татварын авлага	9.2	187,294	—
Бусад хөрөнгө	14	8,142,417	944,155
Биет бус хөрөнгө	15	1,384,180	754,673
Үндсэн хөрөнгө	16	1,984,069	1,510,130
Ашиглах эрхтэй хөрөнгө	17	2,270,617	3,432,748
Хойшлогдсон татварын хөрөнгө	9.3	202,350	180,977
НИЙТ ХӨРӨНГӨ		340,180,862	252,350,872
ӨР ТӨЛБӨР			
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө			
Үүсмэл санхүүгийн хэрэгслүүд	13.2	272,169	—
Орлогын албан татварын өглөг	9.2	—	3,566,405
Түрээсийн өр төлбөр	17	2,761,771	3,636,405
Зээлээр авсан санхүүжилт	18	230,116,122	169,933,377
Бусад өр төлбөр	19	5,062,025	2,263,734
Хойшлогдсон татварын өр төлбөр	9.3	138,221	19,776
НИЙТ ӨР ТӨЛБӨР		238,350,308	179,419,697
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	20.1	10,756,859	10,756,859
Халаасны хувьцаа	20.2	(2,337,547)	(2,337,547)
Бусад нөөц	20.3	57,348	57,348
Хуримтлагдсан ашиг		93,353,894	64,454,515
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		101,830,554	72,931,175
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		340,180,862	252,350,872

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компаниуд
2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Хувьцаат капитал Мян.төг Тод. 20.1	Халаасны хувьцаа Мян.төг Тод. 20.2	Бусад нөөц Мян.төг Тод. 20.3	Хуримтлагдсан ашиг Мян.төг	Нийт ээдийн өмч Мян.төг
2024 оны 1 сарын 1- ний байдлаар	10,756,859	(2,337,547)	57,348	34,255,279	42,731,939
Нийт бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх тайлант жилийн цэвэр ашиг	—	—	—	36,113,649	36,113,649
Олгосон ногдол ашиг (Тод. 21.1)	—	—	—	(5,914,413)	(5,914,413)
2024 оны 12 сарын 31-ний байдлаар	10,756,859	(2,337,547)	57,348	64,454,515	72,931,175
Нийт бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх тайлант жилийн цэвэр ашиг	—	—	—	40,078,942	40,078,942
Олгосон ногдол ашиг (Тод. 21.1)	—	—	—	(11,089,521)	(11,089,521)
Охин компани данснаас хасалт	—	—	—	(90,042)	(90,042)
2025 оны 12 сарын 31-ний байдлаар	10,756,859	(2,337,547)	57,348	93,353,894	101,830,554

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компаниуд
2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

	Notes	2025 Мян.төг	2024 Мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		48,964,203	46,127,260
<i>Тохируулгууд:</i>			
Зээлээр авсан эх үүсвэрийн хүүний зардал	5	36,411,279	21,064,144
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний зардал	5	—	788,160
Түрээсийн өрийн хүүний зардал	5, 17	607,616	329,240
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт	6, 12.1	31,557,683	8,157,556
Ирээдүйд харилцагчдад олгохоор тооцсон зээлийн үнэ цэнийн бууралт	6, 19	71,680	41,106
Үндсэн хөрөнгө болон ашигах эрхтэй хөрөнгийн элэгдэл	7	1,089,836	831,083
Биет бус хөрөнгийн хорогдуулалт	7, 15	96,901	45,383
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй гарз	8	66,022	299,310
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз	8, 13.1	(245,079)	(89,889)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз	8, 13.2	(340,041)	—
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас данснаас хассаны гарз	8	—	15,580
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	8, 16	799	29,418
Түрээс данснаас хассаны олз	8, 17	(99,013)	—
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг		118,181,886	77,638,351
Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны өсөлт		(107,539,997)	(116,422,750)
Бусад хөрөнгийн өсөлт		(7,209,262)	(466,175)
Бусад өглөгийн өсөлт/(бууралт)		2,726,611	(2,155,315)
Охин компани худалдан авалттай холбоотой өсөлт		(222,805)	—
Үйл ажиллагаа (-нд зарцуулсан)/-наас олсон цэвэр мөнгөн гүйлгээ		5,936,433	(41,405,889)
Төлсөн орлогын татвар	9.2	(12,533,591)	(10,115,736)
Гуравдагч талд суутгуулсан татвар	9.2	(17,182)	(98,938)
Түрээсийн өр төлбөрийн хүүний төлөлт	17	(607,616)	(329,240)
Зээлээр авсан эх үүсвэрийн хүүний төлөлт		(27,597,639)	(18,411,572)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(34,819,595)	(70,361,375)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн худалдан авалт	13.1	—	(1,004,659)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн худалдан авалт		(33,000)	—
Биет бус хөрөнгийн худалдан авалт	15	(637,755)	(444,514)
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	16	(765,940)	(1,388,431)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(1,436,695)	(2,837,604)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компаниуд
2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (Үргэлжлэл)

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Бондын санхүүжилтээс орсон мөнгө	7,082,470	20,304,199
Зээлээр авсан санхүүжилтээс орсон мөнгө	423,433,676	169,565,553
Итгэлцлээр авсан санхүүжилтээс орсон мөнгө	143,982,745	111,577,773
Бондын санхүүжилтийн төлөлт	(14,942,226)	(3,580,628)
Зээлээр авсан санхүүжилтийн төлөлт	(368,648,632)	(122,725,192)
Итгэлцлээр авсан санхүүжилтийн төлөлт	(139,605,470)	(85,928,111)
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эргэн төлөлт	—	(4,753,065)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт	(348,129)	(529,995)
Олгосон ногдол ашиг	20.1 (11,089,521)	(5,914,413)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	39,864,913	78,016,121

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	3,608,623	4,817,142
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	520	2,964
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11 12,706,074	7,885,968
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11 16,315,217	12,706,074

Хүүнээс үүссэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүлээн авсан хүү	131,518,738	85,404,552

Мөнгөн бус гүйлгээ:		
Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийн өсөлт	17 —	3,448,589
Дуусах хугацаанаас өмнө цуцлагдсан түрээсийн гэрээ	17 (526,505)	(263,831)

Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга:

	Зээлээр авсан санхүүжилт		Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	
	2025 Мян.төг	2025 Мян.төг	2025 Мян.төг	2025 Мян.төг
1 сарын 1-нээр	169,933,377	77,445,677	—	4,798,243
Шинээр нэмэгдсэн	574,495,541	301,447,525	—	—
Төлөгдсөн	(523,196,328)	(212,233,931)	—	(4,753,065)
Тайлант жилийн хүүгийн зардал	36,411,279	22,164,503	—	788,160
Төлсөн хүү	(27,597,639)	(18,678,593)	—	(833,338)
Вальютын ханшийн хөдөлгөөн	69,892	(211,804)	—	—
12 сарын 31-нээр	<u>230,116,122</u>	<u>169,933,377</u>	<u>—</u>	<u>—</u>

1 Компанийн талаарх мэдээлэл

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх) нь Монголын Хөрөнгийн Биржид (цаашид “МХБ” гэх) бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, хувь нийлүүлсэн хувьцаат компани. Компани нь 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдөр МХБ дээр бүртгэлтэй болсноор нээлттэй хувьцаат компани болсон. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос (цаашид “СХЗ” гэх) 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр олгосон 1/493 тоот банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн дагуу зээлийн үйл ажиллагааг явуулж байна. Түүнчлэн Компани нь СХЗ-оос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр олгогдсон 45 тоот дугаартай Итгэлцлийн болон Факторингийн үйлчилгээ, 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр олгосон 128 тоот дугаартай гадаад валютын арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүдийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Үндсэн үйл ажиллагаа. Компани нь зэргэлдээ охин компани болох Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Анд Системс Тех ХХК-ийн хөгжүүлэн гаргасан ЛэндМН технологийг ашиглан зээлийн үйлчилгээг хангалттай хэмжээнд авч чаддаггүй хүмүүст гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу 24/7 цахим зээлийн үйлчилгээг үзүүлдэг. ЛэндМН технологи нь Анд Системс Тех ХХК -ийн хөгжүүлэн гаргасан “финтек” шийдэл бүхий технологи бөгөөд технологийн лицензийг Анд Системс Тех ХХК-ээмшдэг. 2018 онд Компани нь ЛэндМН технологиор дамжуулан төрөл бүрийн төлбөр тооцоо, санхүүгийн гүйлгээ хийх “Лэнд Хэтэвч” шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлсэн.

Компанийн толгой компани нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек компани болох АНД Глобал ПиТиИ. Лтд юм.

2024 оны 5 дугаар сарын 27-нд Компани нь ЛэндМН СМЭ ББСБ ХХК хэмээх шинэ охин компанийг байгуулсан. Энэхүү байгууллагын зорилго нь 2024 онд Компанийн нэвтрүүлсэн жижиг, дунд үйлдвэр (“ЖДҮ”)-ийн эзэмшигчдэд олгосон хэрэглээний зээлийн үйлчилгээг шилжүүлэн авах явдал юм. Оны эцсийн байдлаар тус охин компанийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байна.

Компанийн 100 хувь эзэмшлийн охин компани болох ЛэндМН Актив ТЗК ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны (“ХБҮЦ”) хөтөлбөрийн үйл ажиллагаа дууссаны дараа 2025 онд татан буугдсан. Энэхүү охин компанийг 2022 оны 7 дугаар сарын 3-нд Компанийн зээлийн багцуудыг худалдан авч, 2022 оны 8 дугаар сарын 4-нд СЗХ-ноос авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд ХБҮЦ гаргах зорилгоор байгуулсан. ХБҮЦ-ийн хугацаа нь 2024 оны 10 дугаар сард дууссан бөгөөд үүний дараа зээлийн багцуудыг Компанид буцаан шилжүүлсэн.

2025 оны 12 дугаар сарын 1-нд Компани нь ижил удирдлага дор байдаг аж ахуйн нэгж болох Супер Ап Хэтэвч ХХК-ийн 100% эзэмшлийн эрхийг холбоотой тал болох АНД Системс ХХК-аас худалдан авсан. Супер Ап Хэтэвч ХХК нь 2020 оны 1 дүгээр сарын 9-нд байгуулагдсан бөгөөд ЛэндМН гар утасны аппликейшнаар дамжуулан дижитал хэтэвч болон төлбөрийн шийдлүүдийг хангах зорилгоор Монгол банкнаас олгосон 06 тоот дугаартай цахим мөнгөний үйлчилгээний лицензийг авсан.

Энэхүү хэлцэл нь нийтлэг хяналт дор байгаа аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдсэн гүйлгээ тул СТОУС 3 ‘Бизнесийн нэгтгэл’-ийн хамрах хүрээнээс гадуур байна. Группийн нийтлэг хяналтын хэлцлийг бүртгэх бодлогын дагуу уг худалдан авалтыг “ашиг сонирхлыг нэгтгэх арга”-аар бүртгэн тооцсон. Энэ аргын дагуу Супер Ап Хэтэвч ХХК -ийн хөрөнгө, өр төлбөрийг тухайн үеийн дансны дүнгээр нь хүлээн зөвшөөрч, гүүдвил болон бодит үнэ цэнийн тохируулга хийгдэхгүй.

Худалдан авалтын үед төлсөн төлбөр нь Супер Ап Хэтэвч ХХК -ийн цэвэр хөрөнгийн дансны дүнтэй тэнцүү байсан бөгөөд төлсөн төлбөр болон цэвэр хөрөнгийн дансны дүнгийн хооронд ямар нэгэн зөрүү үүсээгүй ба үүний улмаас энэхүү хэлцэлтэй холбоотойгоор өмчийн дансны аль нэг нөөцөд ямар нэгэн бүртгэл хийгдээгүй.

“Ашиг сонирхлыг нэгтгэх” аргачлалд баримталдаг Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу харьцуулсан мэдээллийг дахин гаргаагүй бөгөөд Супер-Ап Хэтэвч компанийн үр дүн болон санхүүгийн байдлыг 2025 оны 12-р сарын 1-ний худалдан авалтын өдрөөс эхлэн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгасан.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөг (“төг”)-өөр тайлагнасан. Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг 2026 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлан гаргасан.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

Тайлан бэлтгэх үндэслэл. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс бэлтгэн гаргасан СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартуудийн дагуу бэлтгэгдсэн. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг үүсмэл санхүүгийн хэрэгслүүд болон бодит үнэ цэнийг ашиг алдагдлаар ("БҮЦАА") хэмжих санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдээс бусад тохиолдолд түүхэн өртгийн аргаар бэлтгэсэн болно. Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Эдгээр бодлого нь өөрөөр заагаагүй бол (Тодруулга 3-т дурдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг оролцуулаад) толилуулж буй бүх тайлант үед ижил мөрдөгдсөн болно.

Санхүүгийн тайлангийн толилуулга. Групп санхүүгийн байдлын тайланг түргэн хөрвөх дарааллаар өргөн хүрээнд толилуулдаг. Тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор (эргэлтийн) болон тайлангийн өдрөөс хойш 12 сараас илүү хугацааны дотор (эргэлтийн бус) эргэн төлөгдөх зохицуулалттай холбоотой дүгнэлтийг Тодруулга 25-д оруулав.

Нэгтгэлийн үндэслэл. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компанийн болон түүний охин компаниудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ. Компанийн хяналтад байгаа охин компаниудыг нэгтгэн тайлагнана. Групп нь тухайн нэгж дээр хяналт тогтоосон гэж үзэх нөхцөл нь Групп хөрөнгө оруулалтын нэгжид оролцох замаар хувьсах өгөөж авах эрсдэлд өртөх, эсвэл тийм өгөөж авах эрхтэй байх бөгөөд мөн эдгээр өгөөжид нөлөөлөх боломжийг олгодог эрх мэдлийг тухайн нэгж дээр хэрэгжүүлэх чадвартай байх явдал юм. Тодруулбал, Групп дараах нөхцөлүүд биелсэн тохиолдолд хөрөнгө оруулалсан нэгжийг хянаж байгаа гэж үзнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалсан нэгжийн холбогдох үйл ажиллагааг удирдах эрх мэдэлтэй байх (өөрөөр хэлбэл, тухайн үйл ажиллагааг чиглүүлэх хүчин төгөлдөр эрхтэй байх);
- Хөрөнгө оруулалсан нэгжид оролцсоноор өгөөжийн эрсдэлд өртөх, эсвэл тийм өгөөж авах эрхтэй байх; болон
- Энэ эрх мэдлээ ашиглан өгөөжийн хэмжээнд нөлөөлөх чадвартай байх.

Ерөнхийдөө саналын эрхийн дийлэнх хувийг эзэмшдэг бол тухайн нэгжид хяналт тогтоно гэж үздэг. Гэсэн хэдий ч Групп хөрөнгө оруулалтын нэгжийн саналын эрх болон түүнтэй адилтгах эрхийн дийлэнх хувийг эзэмшдэггүй нөхцөлд, дээрх таамаглалыг баталгаажуулахын тулд бүх холбогдох баримт, нөхцөл байдлыг иж бүрнээр нь үнэлж хяналт тогтоож буй эсэхийг тодорхойлно. Үүнд, ноцтой ач холбогдол бүхий дараах хүчин зүйлсийг тусган авч үзнэ:

- Хөрөнгө оруулалтын нэгжийн зорилго, бүтэц, зохион байгуулалтын зарчим;
- Холбогдох үйл ажиллагаа, эдгээр үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах механизм, мөн Компанийн тухайн үйл ажиллагааг чиглүүлэх чадвар;
- Санал гаргах эрх, буцаан худалдах эрх, татан буулгах эрх зэрэг гэрээний хүрээнд тогтоосон эрх, үүргийн зохицуулалт;
- Компанийн хөрөнгө оруулалтын нэгжтэй холбогдон өгөөжийн эрсдэлд өртөх, эсвэл тийм өгөөж авах эрхтэй байх, мөн эдгээр өгөөжийн хэлбэлзэлд нөлөөлөх эрх мэдлийг хэрэгжүүлэх боломжтой байх эсэх.

Групп нь хяналтын гурван бүрэлдэхүүн хэсгийн аль нэгэнд нь өөрчлөлт орсон болохыг илтгэх баримт болон нөхцөл байдал илэрсэн тохиолдолд, тухайн хөрөнгө оруулалтын нэгж дээр хяналт тогтоож байгаа эсэхээ дахин үнэлнэ. Охин компаниудыг нэгтгэн тайлагнах үйл явц нь Групп тухайн охин компанид хяналт тогтоосон өдрөөс эхэлж, хяналтаа алдсан өдрөөр дуусгавар болно. Тайлант хугацаанд олж авсан эсвэл худалдаж авсан охин компаниудын хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардлыг Групп хяналт тогтоосон өдрөөс эхлэн, хяналтаа алдсан өдрийг хүртэлх хугацаанд нэгтгэсэн ашиг, алдагдлын тайланд тусгана.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Нэгтгэлийн үндэслэл (үргэлжлэл)

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн хэсэг бүрийг Группийн эцсийн өмчлөгчдийн өмчид болон хяналтын бус эзэмшигчдийн өмчид харгалзуулан хуваарилна; ингэхэд хяналтын бус эзэмшигчийн өмч сөрөг үлдэгдэлтэй болох нөхцөл байдал байж болно. Шаардлагатай бол охин компаниудын санхүүгийн тайланг Группийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлоготой нийцүүлэхийн тулд тохируулга хийнэ. Группийн гишүүн нэгжүүдийн хооронд хийгдсэн бүх гүйлгээ, түүнтэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардал болон мөнгөн гүйлгээг нэгтгэх явцад бүрэн арилгадаг.

Охин компанид эзэмшлийн хувьд өөрчлөлт орсон боловч хяналтаа алдаагүй тохиолдолд, уг өөрчлөлтийг өмчийн гүйлгээ гэж бүртгэнэ. Харин Групп охин компанид хяналтаа алдах тохиолдолд, тухайн охин компанитай холбоотой бүх хөрөнгө (гүүдвилыг багтаан), өр төлбөр, хяналтын бус хувь оролцоо болон өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийг тайлангаас дансны үнээр нь хасна. Үүссэн ашиг буюу алдагдлыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Хяналтаа алдсаны дараа хадгалсан ямар ч хөрөнгө оруулалтыг тухайн өдрийн бодит үнэ цэнээр хэмжиж хүлээн зөвшөөрнө.

Тасралтгүй байх зарчим. Группийн удирдлага үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх байдлыг үнэлж, группд ойрын ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах хангалттай нөөц бололцоо байгаа гэж үзсэн байна. Мөн удирдлага группийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадварт ноцтой эргэлзээ төрүүлэхүйц ямар нэгэн бодитой тодорхойгүй нөхцөл байдлыг илрүүлээгүй байна. Иймд нэгтгэсэн санхүүгийн тайланг ‘тасралтгүй үйл ажиллагааны зарчим’-аар бэлтгэн гаргасан болно

Нийтлэг хяналтанд байгаа компаниудын бизнесийн нэгдэл. Групп нь нийтлэг хяналтанд байгаа бизнесийн нэгтгэлд “ашиг сонирхлыг нэгтгэх арга”-ыг нягтлан бодох бүртгэлийн бодлогоор сонгон хэрэглэнэ. Уг аргачлалын хүрээнд дараах зарчмууд мөрдөгдөнө:

- Олж авсан нэгжийн хөрөнгө ба өр төлбөрийг өмнөх өмчлөгчийн дансны дүнгээр хүлээн зөвшөөрнө, эдгээр нь ихэвчлэн толгой компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан дүн байна.
- Бодит үнэ цэнийн залруулга хийгдэхгүй бөгөөд шинэ гүүдвил хүлээн зөвшөөрөгдөхгүй.
- Энэхүү хэлцэл нь нийтлэг хяналтын дор хийгдсэн дахин зохион байгуулалтын шинжтэй тул шилжүүлсэн төлбөр болон олж авсан цэвэр хөрөнгийн дансны дүнгийн хоорондын зөрүүг (хэрэв байгаа бол) бодит бизнесийн худалдан авалт биш гэж үзэж эздийн өмчийн бүртгэлд шууд тусгагдана.

Гүйцээн мөрдөх аргачлалын хэрэглээ – Групп нь өмнөх өмчлөгчийн аргын хүрээнд зөвшөөрөгдсөн хоёр хандлагын нэг болох гүйцээн мөрдөх аргачлалыг ашиглана. Энэ аргачлалын дагуу хэлцлийг Групп тухайн нэгжид хяналт тогтоосон өдрөөс эхлэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Харьцуулсан тайлант үеийн үзүүлэлтүүдийг дахин тайлагнахгүй бөгөөд өмнөх тайлант үеийн санхүүгийн үр дүн нь олж авсан бизнесийн мэдээлэл болон гүйцэтгэлийг нэгтгэхгүй.

Санхүүгийн хэрэглүүр – Хүлээн зөвшөөрөх хугацаа. Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа болон бусад авлагаас бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь арилжааны өдөр буюу Группийн тухайн хэрэгслийн гэрээний оролцогч тал болсон өдрөөр хийгдэнэ. Үүнд зах зээлийн зохицуулалт эсвэл журмаар тогтоосон хугацаанд хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл борлуулах ердийн арилжаа багтана. Харилцагчдад олгосон зээл болон бусад авлагыг харилцагчийн данс руу хөрөнгө шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт. Анх хүлээн зөвшөөрөх үеийн санхүүгийн хэрэгслүүдийн ангилал нь тэдгээрийн гэрээний нөхцөл болон тухайн хэрэгслийг удирдах бизнесийн загвараас хамаарна. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд (“БҮЦАА”) бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэдэг. Компанийн бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх зах зээлийн үнэ дээр гүйлгээний зардал нэмсэн дүнгээр бүртгэгддэг.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

Гүйлгээний зардал нь санхүүгийн хэрэглүүрийг худалдан авах, худалдах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээ хийгээгүй тохиолдолд гарахгүй байх байсан зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч (мөн борлуулалтын агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад), зөвлөхүүд, брокерууд болон дилерүүдэд төлсөн шимтгэл, хураамж, зохицуулах байгууллага, хөрөнгийн зах зээлийн байгууллагад төлсөн төлбөр, шилжүүлгийн татвар, хураамж хамаарна. Гүйлгээний зардалд өрийн шимтгэл эсвэл хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, удирдлагын дотоод зардал, хадгалалтын зардал орохгүй.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн ангилал болон хэмжилт. Компани нь санхүүгийн хөрөнгүүдийг хэмжилтээр нь тухайн багцыг удирдах компанийн бизнес загвар болон хөрөнгийн гэрээний нөхцөлөөс хамааруулан дараах байдлаар ангилна:

- Хорогдуулсан өртгөөр,
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод ("БҮЦБДО") бүртгэгдэх, эсвэл
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд ("БҮЦАА") бүртгэгдэх гэж ангилна.

Компани үүсмэл санхүүгийн хөрөнгө болон арилжааны багцаа БҮЦАА-аар ангилж хэмждэг. Хэрэв орлогын тайлангийн хэлбэлзлийг арилгах эсхүл мэдэгдэхүйц бууруулах тохиолдолд тухайн санхүүгийн хэрэглүүрийг БҮЦАА ангилж болно.

Ирээдүйд олгохоор тооцсон зээл болон санхүүгийн баталгаанаас бусад санхүүгийн өр төлбөрийг арилжааны болон үүсмэл хэрэгслийн зориулалтаар эзэмших эсвэл бодит үнэ цэнийн аргыг хэрэглэх үед хорогдуулсан өртгөөр эсвэл БҮЦАА-ээр хэмждэг.

Бодит үнэ цэнэ нь хэмжилт хийгдэх тухайн өдөр зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх байсан үнийг хэлнэ. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бол идэвхтэй зах зээл дээрх үнэ байдаг. Идэвхтэй зах зээл гэдэг нь давтамж, тоо хэмжээний хувьд үнийн мэдээллийг тогтмол нийлүүлж чадах хөрөнгө, өр төлбөртэй холбоотой гүйлгээ гарч байдаг зах зээлийг хэлдэг.

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж байгаа санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хөрөнгө буюу өр төлбөр тус бүрийн жишиг үнэ болон аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хэрэглүүрүүдийн тоо хэмжээгээр хэмждэг. Зах зээлийн өдөр тутмын хэвийн арилжааны хэмжээ нь компанийн эзэмшиж байгаа тоо хэмжээтэй харьцуулахад хангалтгүй байх, мөн нэг арилжаагаар борлуулах захиалгын тоо хэмжээ зэрэг нь жишиг үнэнд нөлөөлөх тохиолдол ч мөн байна.

Зах зээлийн мэдээлэл хомс зарим санхүүгийн хэрэглүүрийн хувьд тэдгээрийн бодит үнэ цэнийг хорогдуулсан мөнгөн урсгалын арга, харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд сүүлд хийгдсэн ажил гүйлгээ эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл зэргийг үндэслэсэн аргаар тооцоолно.

Бодит үнэ цэнийн хэмжилтийг бодит үнэ цэнийн шатлалын дагуу дараах байдлаар шинжилдэг. Үүнд: (i) Нэгдүгээр түвшин нь ижил хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээл дээрх жишиг үнэнд (залруулагдаагүй) үндэслэн хийсэн хэмжилт, (ii) Хоёрдугаар түвшин хэмжилт нь тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс тооцон гаргасан) ажиглагдахуйц бүхий л материаллаг хэмжээний орц мэдээллийг ашиглах үнэлгээний арга, техникүүд (iii) Гуравдугаар түвшин хэмжилт нь зах зээлээс ажиглагдахуйц бус тоо мэдээнд үндэслэн хийсэн үнэлгээнүүд (хэмжилт нь чухал, үл ажиглагдахуйц орц мэдээллийг шаарддаг) орно. Бодит үнэ цэнийн шатлалын түвшин хоорондын шилжүүлэг нь тайлант хугацааны эцэст гарсан гэж тооцогдоно.

Санхүүгийн хөрөнгө - Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа. Групп нь Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааг зөвхөн дараах хоёр нөхцөл хангагдсан тохиолдолд хорогдуулсан өртгөөр хэмждэг:

- Гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загварын хүрээнд санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг;
- Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцлүүд нь тодорхой өдөр мөнгөн гүйлгээг бий болгодог бөгөөд энэ нь зөвхөн үндсэн төлөлт болон хүү ("ЗҮТХ") юм.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө - Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

Группийн бизнесийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирддагийг хамгийн сайн илэрхийлэх түвшинд бизнесийн загварыг тодорхойлдог. Группийн бизнесийн загварыг хэрэгслээс хэрэгсэл болгон тус тусад нь үнэлдэггүй бөгөөд илүү өндөр түвшний нэгтгэсэн багцын түвшинд үнэлдэг.

Ангиллын үйл явцын хоёр дахь алхам болгон Группийн зүгээс санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг үнэлж, тэдгээр нь ЗҮТХ шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно. Энэхүү шалгуурын хүрээнд 'үндсэн дүн' нь санхүүгийн хөрөнгийг анх бүртгэх үеийн бодит үнэ цэнэ гэж тодорхойлогдох бөгөөд санхүүгийн хөрөнгийн хугацаанд өөрчлөгдөж болно (жишээлбэл, үндсэн төлбөр төлөгдөх, эсвэл нэмэгдэл/хөнгөлөлтийн хорогдол тооцогдох үед). Зээлийн зохицуулалтын хүрээнд хүүгийн хамгийн чухал бүрдлүүд нь ихэвчлэн мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн эрсдэл байдаг.

Хорогдуулсан өртөг нь санхүүгийн хэрэгслийг анх бүртгэсэн өртгөөс үндсэн төлбөрүүдийг хасч, хуримтлагдсан хүүг нэмсэн дүн бөгөөд санхүүгийн хөрөнгийн хувьд гарсан данснаас хасалт болон хүлээгдэж буй алдагдлыг хассан дүн байна. Хуримтлагдсан хүү нь анхдагч хүлээн зөвшөөрөлтийн хойшлуулсан гүйлгээний зардлын хорогдуулсан дүн болон үр ашигт хүүний аргыг ("YAXA") ашиглан хугацаа дуусахад төлөгдөх дүнтэй харьцуулахад үүссэн урамшуулал эсвэл хөнгөлөлтийн хорогдуулалтыг хамарна.

Хуримтлагдсан хүүний орлого болон хуримтлагдсан хүүний зардлын хувьд хуримтлагдсан купон болон урамшуулал эсвэл хөнгөлөлтийн хорогдуулалт (шаардлагатай бол анхдагч үеийн хойшлуулсан хураамжийг багтаана) зэрэг нь тусдаа тайлагнагдахгүй бөгөөд санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох дүнд шингэсэнээр тусгагдана

Ирээдүйд олгохоор тооцсон зээл нь Групп-ын харилцагчдад урьдчилан тохирсон нөхцөлөөр зээл олгох үүрэг хүлээсэн амлалт юм.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдалд толилуулагдах үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэдэг нь дараах гурван шинжийг бүгдийг нь агуулсан санхүүгийн хэрэгсэл эсвэл бусад гэрээний хэлцэл юм:

- Тодорхой хүүгийн түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн индекс эсвэл хүүгийн индекс, зээлийн зэрэглэл эсвэл зээлийн индекс, эсвэл бусад хувьсагчийн өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх замаар түүний үнэ цэнэ өөрчлөгддөг бөгөөд санхүүгийн бус хувьсагчийн хувьд энэ нь гэрээний тал (өөрөөр хэлбэл 'үндсэн')-д онцгойлон хамаардаггүй.
- Энэ нь анхдагч цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй, эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөд ижил төстэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээнээс шаардагдах цэвэр анхдагч хөрөнгө оруулалтаас бага хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг.
- Тухайн гэрээ нь ирээдүйд тогтоосон хугацаанд тооцоо хийгдэж хаагдана.

Групп харилцагч талуудтай үүсмэл хэлцлүүдийг байгуулдаг. Эдгээр нь зөвхөн хөрвөх ханшийн своп хэлцлүүдийг хамарна. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэж, бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгө, сөрөг бол өр төлбөр хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн өөрчлөлтийг бусад цэвэр орлого/(зардал)-д тусгана.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөр – Гаргасан өрийн хэрэгслүүд болон зээлээр авсан санхүүжилт.

Гаргасан өрийн хэрэгслүүд болон бусад зээлээр авсан санхүүжилтүүд нь дотоод болон гадаадын санхүүгийн байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу үүссэн үүрэг хариуцлага юм.

Анхдагч хэмжилтийн дараа гаргасан өрийн хэрэгслүүд болон бусад зээлээр авсан санхүүжилтыг үр ашигт хүүний аргыг (ҮАХА) ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Гаргасан өрийн хэрэгслүүд болон бусад зээлээр авсан санхүүжилтын хорогдуулсан өртгийг ҮАХА-ыг ашиглан, уг хэлцэлтэй холбоотой бүх гүйлгээний зардлыг харгалзан тооцно.

Группийн гаргасан өрийн хэрэгслүүд болон бусад санхүүжилтын дэлгэрэнгүйг 18 болон 19-р тодруулгад тайлбарлан толилуулсан.

Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах. Санхүүгийн хөрөнгө (эсвэл санхүүгийн хөрөнгийн тодорхой хэсэг, эсвэл түүнтэй ижил төрлийн санхүүгийн хөрөнгийн хэсэг)-ийг түүний мөнгөн урсгал хүлээн авах эрх дуусгавар болсон үед данснаас хасна.

Санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах. Санхүүгийн өр төлбөрийг түүнд холбогдох үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл дуусгавар болсон үед данснаас хасна. Хэрэв одоогийн санхүүгийн өр төлбөрийг ижил зээлдүүлэгчтэй, боловч үндсэндээ өөр нөхцөлтэй шинэ өр төлбөрөөр солих, эсвэл одоогийн өр төлбөрийн нөхцөл үндсэндээ өөрчлөгдвөл, ийм солилцоо эсвэл өөрчлөлтийг эхний өр төлбөрийг данснаас хасч, шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Эхний санхүүгийн өр төлбөрийн дансны дүн болон төлсөн төлбөрийн хоорондын зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үр ашигт хүүгийн арга. СТОУС 9 стандартын дагуу хорогдуулалтын өртгөөр хэмжигддэг бүх санхүүгийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар (ҮАХА) бүртгэнэ. ҮАХА нь санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй хугацаанд (эсвэл шаардлагатай бол богино хугацаанд) хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалуудыг тухайн санхүүгийн хөрөнгийн цэвэр дансны дүнтэй тэнцүүлэх байдлаар тооцох хүүгийн хувь юм. ҮАХА-ыг (мөн хөрөнгийн хорогдуулсан өртгийг) тооцохдоо хөрөнгийг худалдан авах үед үүссэн урамшуулал, хөнгөлөлт, шимтгэл болон ҮАХА-ийн салшгүй хэсэг болох зардлуудыг харгалзан үзнэ.

Группийн зүгээс зээлийн хүлээгдэж буй хугацаанд тогтвортой өгөөжийн түвшинг хамгийн сайн илэрхийлэх өгөөжийн хувь хэмжээг ашиглан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрдөг. Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг бүх санхүүгийн өр төлбөрийн хувьд хүүгийн зардлыг мөн ҮАХА-г ашиглан тооцно.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт. Групп БҮЦАА бүртгэгддэгээс бусад харилцагчдад олгосон зээл болон өрийн шинжтэй санхүүгийн хөрөнгө, түүнчлэн ирээдүйд харилцагчдад олгохоор тооцсон зээл зэргийн хувьд хүлээгдэж буй зээлийн эрсдлын алдагдлын санг бүртгэн тооцдог.

Зээлийн төлбөр төлөгдөхгүй байх магадлалын тодорхойлолт. Групп нь зээлдэгч гэрээний төлбөрөө 90 хоногоор хэтрүүлсэн бүх тохиолдолд, мөн бүтцийн өөрчлөлт хийсэн 2-р шатлалын зээлийг оруулаад чанар муудсан зээлүүдийг 3-р шатлал (үнэ цэнэ буурсан) гэж үздэг. Групп банкны үлдэгдэл болон бусад авлагыг тухайн гэрээнд заасны дагуу ажлын өдөр дуусахад шаардлагатай өдрийн төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд чанар муудсан гэж үзэж яаралтай арга хэмжээ авдаг.

Хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХБЗА)-ын аргачлалын тойм. ХБЗА-ын сан нь хөрөнгийн бүх хугацаанд үүсэхээр хүлээгдэж буй зээлийн алдагдалд (зээлийн нийт хугацааны турш хүлээгдэж буй зээлийн алдагдал буюу НХХБЗА) үндэслэнэ. Харин үүссэн үеэс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гараагүй бол сан нь 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдал (12 сарын ХБЗА)-д үндэслэнэ. 12 сарын ХБЗА нь нийт хугацааны ХБЗА-ийн нэг хэсэг бөгөөд нэгтгэсэн тайлагналын өдрөөс хойших 12 сарын дотор санхүүгийн хэрэгсэл чанар муутай болох боломжтой нөхцөл байдлаас үүдэн бий болж болох ХБЗА-ыг илэрхийлдэг.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл).

Үүн дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг доор дурдсан Шатлал 1, Шатлал 2, Шатлал 3 болон худалдан авсан эсвэл анхдагч үеийн үнэ цэнэ буурсан (ХАҮЦБ) гэсэн ангилалд хуваарилна:

- Шатлал 1: Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хүлээгдэж буй 12 сарын ХБЗА-д үндэслэн сан байгуулна.
- Шатлал 2: Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл анхдагч үеэс мэдэгдэхүйц өссөн тохиолдолд сан нь НХХБЗА-д үндэслэнэ.
- Шатлал 3: Зээлийн чанар муудсан гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн үед зээлийн эрсдлийн санг НХХБЗА-д үндэслэнэ.
- ХАҮЦА: Анх хүлээн зөвшөөрөх үеийнхээ нөхцөлөөр чанар муутай гэж ангилагдсан, худалдан авсан эсвэл олгосон үеийн чанар муутай санхүүгийн хөрөнгө. ХАҮЦА хөрөнгийг анх бүртгэхдээ бодит үнэ цэнээр бүртгэж, цаашид хүүний орлогыг зээлийн эрсдэлээр тохируулсан үр ашигт хүүний хувьд үндэслэн хүлээн зөвшөөрнө. ХБЗА -ыг зөвхөн хүлээгдэж буй зээлийн алдагдалд дараагийн өөрчлөлт гарсан хэмжээнд хүлээн зөвшөөрөх буюу буцаана.

ХБЗА-ын тооцоолол. Групп хүлээгдэж буй мөнгөн урсгалын бууралтын хэмжээг тодорхойлох зорилгоор гурван магадлалын хувилбарыг ашиглан ХБЗА-ыг тооцдог. Мөнгөн урсгалын бууралт гэдэг нь гэрээний дагуу тухайн байгууллагад хүлээгдэж буй мөнгөн урсгал болон байгууллага бодитоор хүлээн авахаар тооцож буй мөнгөн урсгалын хоорондын зөрүү юм. ХБЗА-ын тооцооллын механизм дараах байдлаар тайлбарлагдана. Гол бүрдлүүд:

- ТТБМ: Төлбөр төлөгдөхгүй байх магадлал гэдэг нь тодорхой хугацааны туршид чанар муудах боломжит нөхцөлийн үнэлгээ. ТТБМ нь тухайн санхүүгийн хэрэгсэл өмнө нь данснаас хасагдаагүй, зээлийн багцад хэвээр байгаа тохиолдолд үнэлэгдэж буй хугацааны тодорхой мөчид үүсч болно.
- ЧӨД: ХБЗА чанаргүйдэлд өртөх дүн гэдэг нь тайлагналын өдрөөс хойш үндсэн болон хүүний төлбөр гэрээнд заасан төлөлт болон бусад, урьдчилан зөвшөөрсөн зээлийн шугамын ашиглалт, мөн хугацаа хоцорсон төлөлтөөс үүсэх хуримтлагдсан хүү зэрэг өртгийн өөрчлөлтүүдийг харгалзан чанар муудалт гарах ирээдүйн өдрөөр тооцоолсон өртгийн хэмжээ.
- АҮМ: Алдагдал үүсэх магадлал гэдэг нь ТТБМ тодорхой хугацаанд гарсан тохиолдолд Компанид үүсэх алдагдлын төсөөлөл. Энэ нь гэрээний дагуу хүлээгдэж буй мөнгөн урсгал болон Компанийн бодитоор хүлээн авахаар тооцож буй мөнгөн урсгалын зөрүүнд үндэслэнэ. ЧМҮА -ыг ихэвчлэн ЧӨД-ийн хувиар илэрхийлдэг.

ХБЗА-г тооцоолох үед компани гурван хувилбар (суурь тохиолдол, хамгийн таатай тохиолдол болон таагүй тохиолдол)-ыг ашигладаг. Эдгээр хувилбар бүр нь Тодруулга 21.3-д тусгагдсан өөр өөр ТТБМ, ЧӨД болон АҮМ-тай уялдсан байдаг.

Ирээдүйд олгохоор тооцсон зээлийн ХБЗА-ыг тооцоолох үед групп тухайн зээлийн дүнг хүлээгдэж буй хугацаанд хэдий хэмжээгээр ашиглах магадлалтайг үнэлнэ. 2025 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх бодитоор олгосон зээл болон урьдчилгааны хувьд ХБЗА-ыг зээл болон авлагатай хамтад нь тайлагнана. Харин ашиглаагүй зээлийн ХБЗА-ыг нөөцийн дансанд хүлээн зөвшөөрнө.

Ирээдүйн нөхцөл байдлын мэдээлэл. ХБЗА-ын загваруудад групп өргөн хүрээний макро эдийн засгийн урьдчилсан төлөвийн мэдээллийг эдийн засгийн өгөгдөл болгон ашигладаг. Үүнд:

- Дотоодын нийт бүтээгдэхүүн,
- Инфляци,
- Зээлийн нийлүүлтийн өсөлт,
- Сар бүрийн М2- мөнгөний нийлүүлэлт,
- Ажилгүйдлийн түвшин,
- Ажилгүйдлийн түвшний өөрчлөлт,
- Сарын дундаж цалин,
- Сарын гадаадын хөрөнгө оруулалтын түвшин

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Барьцаа. Группийн гол зээлийн бүтээгдэхүүн болон авлагууд болох бичил зээлүүд нь барьцаагүй байдаг. Харин 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн нийт зээлийн багцын 0.5 хувийг эзэлж байсан авто зээлүүд нь зээлдэгчийн худалдан авсан автомашиныг барьцаа болгон авсан байна.

Барьцааг эзэмшилдээ аваагүй тохиолдолд барьцааг группийн санхүүгийн байдлын тайланд бүртгэгдэхгүй. СТОУС-ын дагуу тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагагүй боловч өрийн хэрэгслийн гэрээний нөхцлийн салшгүй бүрэлдэхүүнд тооцогддог, мөн ХБЗА тооцоололд хамрагдах зээлд холбогдох зээлжих чанарын сайжруулалтаас хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тухайн ХБЗА-ын хэмжилтэд багтаана. Иймд барьцааны бодит үнэ цэнэ нь ХБЗА-ын тооцоонд нөлөөлнө. Барьцааг ихэвчлэн анхдагч үе шатанд, мөн улирал тутамд дахин үнэлдэг. Ийм зээлжих чанарын сайжруулалтын нөлөөллийн дэлгэрэнгүй мэдээллийг 21.3-р тодруулгад тайлбарласан.

Боломжтой тохиолдолд Групп барьцаанд байгаа хөрөнгийг үнэлэхдээ сүүлийн үеийн зах зээлийн мэдээллийг ашигладаг.

Данснаас хасах. Хураан төлөгдөх боломжгүй санхүүгийн хөрөнгийг, хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүх ажиллагаа бүрэн хийгдэж, алдагдлын хэмжээ тодорхойлогдсоны дараа, холбогдох зээлийн эрсдлийн сангаас данснаас хасна. Өмнө нь данснаас хасагдсан дүнгийн дараах нөхөн төлөлтүүдийг тухайн тайлант хугацааны ашиг буюу алдагдлын тайлан дахь зээлийн эрсдлийн санд орлого болгон бүртгэнэ.

Мөнгө болон түүнтэй адилтах хөрөнгө. Мөнгө болон түүнтэй адилтах хөрөнгө гэдэг нь тодорхой мөнгөн дүнд түргэн хөрвөх чадвартай бөгөөд үнэ цэнийн өөрчлөлтөнд орох мэдэгдэхүйц эрсдэлгүй хөрөнгийг хэлнэ. Мөнгө болон түүнтэй адилтах хөрөнгөнд гурван сараас бага хугацаатай банканд байршуулсан хөрөнгө хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтах хөрөнгийг YAXA ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Санхүүгийн байдлын тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор хязгаарласан санг мөнгө ба түүнтэй адилтах хөрөнгөнд оруулахгүй.

Үндсэн хөрөнгө. Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тооцож тусгана. Урсгал засвар үйлчилгээний өртгийг тухайн үед нь зардал болгож бүртгэнэ. Бага хэмжээний засвар, өдөр тутмын засвар үйлчилгээний зардлыг гарсан үед зардлаар бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн гол эд ангийг солиход гарсан өртгийг капиталжуулж, хуучин эд ангийг данснаас хасна. Тайлант хугацааны эцэс бүрт удирдлага нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлнэ. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл, удирдлага уг хөрөнгийн нөхөгдөх дүнг хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь тодорхойлдог. Дансны дүнг нөхөгдөх дүн хүртэл бууруулж, холбогдох үнэ цэнийн гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг. Хэрэв үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс зарахад гарах зардлыг хассан дүнг тооцоолоход ашигласан таамаглалд өөрчлөлт орсноос шалтгаалан үнэ цэнийн бууралт багассан тохиолдолд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцааж болно. Үндсэн хөрөнгө борлуулсны олз, гарзыг тухайн үеийн бүртгэлийн дүнтэй харьцуулан тооцож тухайн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо хөрөнгийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь доорх ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилна:

Ашиглалтын хугацаа жилээр

Тавилга, эд хогшил, тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютр, техникийн хэрэгсэл	3 жил
Түрээсийн сайжруулалт	5 жил

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Хөрөнгийн үлдэгдэл үнэ цэнэ гэдэг нь тухайн хөрөнгийг ашиглалтын хугацаа дуусах үед байх гэж тооцогдож буй насжилт, нөхцөл байдлаар нь үзвэл компанийн уг хөрөнгийг борлуулснаар одоо хүлээн авах боломжтой дүнээс борлуулалтын тооцоолсон зардлыг хассан дүн юм. Хөрөнгийн үлдэгдэл үнэ цэнэ болон ашиглалтын хугацааг тайлагналын хугацаа бүрийн эцэст хянаж, шаардлагатай бол өөрчилнө.

Түрээс. Хэрэв гэрээ нь төлбөрийн солилцоогоор тодорхой хугацааны туршид тодорхойлогдсон хөрөнгийн ашиглалтад хяналт тавих эрхийг шилжүүлсэн үед групп уг гэрээг байгуулахдаа гэрээ нь түрээсийн гэрээ мөн эсэх, түрээс агуулж байгаа эсэхийг үнэлдэг.

Групп түрээслэгч үед

Групп богино хугацаатай болон харьцангуй бага өртөгтэй хөрөнгө түрээслэхээс бусад бүх түрээсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих ижил аргыг ашигладаг. Групп түрээсийн төлбөрийг төлөх болон суурь хөрөнгийг ашиглах эрхтэй болсноор түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

i) Ашиглах эрхтэй хөрөнгө

Групп нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн эхлэл өдрөөр (өөрөөр хэлбэл үндсэн хөрөнгийг ашиглах боломжтой болсон өдөр) хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгийн загвараар хэмжих ба хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь хэмжиж, түрээсийн өр төлбөрийн дахин үнэлгээгээр тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт түрээсийн өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрсөн дүн, гарсан анхдагч шууд зардал, түрээс эхлэх өдөр эсвэл түүнээс өмнөх түрээсийн урамшууллыг хассан түрээсийн төлбөр орно. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Ашиглах эрхтэй хөрөнгийг тодруулга 17-д толилуулсан.

ii) Түрээсийн өр төлбөр

Түрээсийн гэрээний эхлэлийн өдрөөр Групп нь түрээсийн нийт хугацааны туршид хийгдэх түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөр (түрээсийн урамшууллыг хассан), индекс эсвэл хувь хэмжээнээс хамааран хувьсах түрээсийн төлбөрүүд, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөх хүлээгдэж буй төлбөрүүд орно. Түрээсийн төлбөрт хэрэгжүүлэх боломжтой худалдан авах сонголтыг хэрэгжүүлэх үнэ, хэрэв түрээсийн хугацаа нь дуусгавар болох сонголтыг тусгаж байгаа бол түрээсийг цуцалсны торгуулийн төлбөрийг багтаана. Индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийг тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход Групп түрээсийн эхлэх өдөр хүчин төгөлдөр байгаа өөрийн өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хэмжээг ашигладаг. Учир нь түрээсийн гэрээнд суурилсан хүүгийн хувийг тодорхойлох боломжгүй байдаг. Түрээс эхэлсэн өдрөөс хойш түрээсийн өр төлбөрийн дүнг хүүний хуримтлалаар өсгөж, хийгдсэн түрээсийн төлбөрөөр бууруулна. Үүнээс гадна, түрээсийн гэрээний өөрчлөлт, түрээсийн хугацааны өөрчлөлт, түрээсийн төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх (жишээлбэл, индекст эсвэл хувь хэмжээнд гарсан өөрчлөлтөөс үүдэн ирээдүйд хийх төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх) тохиолдолд, мөн үндсэн хөрөнгийг худалдан авах сонголтын үнэлгээнд өөрчлөлт орсон үед түрээсийн өр төлбөрийн дансны дүнг дахин хэмжинэ. Дэлгэрэнгүйг Тодруулга 17 -оос үзнэ үү.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Биет бус хөрөнгө. Группийн биет бус хөрөнгүүд нь тодорхой ашиглалтын хугацаатай бөгөөд голчлон капиталжуулсан лицензүүд болон үйлчилгээний лицензүүд багтана. Худалдаж авсан компьютерийн программын лицензийг тэдгээрийг худалдан авах болон ашиглахад бэлэн болгоход гарсан зардлын үндсэн дээр капиталжуулна. Биет бус хөрөнгийг ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна.

Ашиглалтын хугацаа жилээр

ЛэндМН технологийн лиценз (Лэнд болон хэтэвчийн систем) 10 жил

Хэрэв үнэ цэнэ буурсан бол биет бус хөрөнгийн дансны өртгийг ашиглалтын үнэ ба бодит үнэ цэнээс хөрөнгийг хасахтай холбоотой зардлыг хассан дүнгийн аль их дүнгээр нь бууруулан бүртгэнэ.

Орлогын албан татвар. Орлогын албан татвар нь нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлант хугацааны эцсийн байдлаар батлагдсан эсвэл үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжийн хүрээнд хуримтлуулан бүртгэгдсэн байна. Орлогын албан татварын зардал нь тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд эздийн өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Тайлант хугацааны албан татвар нь тухайн болон өмнөх тайлант хугацааны татвар ногдуулах ашиг эсвэл алдагдлаас бодогдсон татварын байгууллагад төлөх эсвэл буцаан авах дүн байна. Нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох татварын тайланг тушаахаас өмнө баталгаажуулсан тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилсан тооцоон дээр үндэслэж тооцдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Хойшлогдсон татварыг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед хэрэглэхээр хүлээгдэж байдаг. Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасч ашиглаж болохуйц хэмжээгээр л хүлээн зөвшөөрнө.

Татварын тодорхой бус байдал. Тайлант хугацааны эцэс бүрд Группийн удирдлага татварын тодорхой бус нөхцөл байдлыг үнэлдэг. Орлогын татварын байр суурийг татварын байгууллага хүлээн зөвшөөрөхгүй байж болохоос шалтгаалан нэмэлт татвар ногдуулах нь ногдуулахгүй байхаас илүү магадлалтай гэж удирдлага үзсэн тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн тайлангийн эцсийн өдрийн байдлаар бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан хууль тогтоомжийн тайлбар болон ижил төрлийн асуудлыг шүүх байгууллагын шийдвэрлэсэн байдал дээр үндэслэн үнэлгээг хийдэг. Торгууль, алданги болон орлогын бус татвартай холбоотой өр төлбөрийн хувьд тайлант хугацааны эцсийн байдлаарх өр төлбөрийг барагдуулахад шаардагдах зардлыг удирдлагын хамгийн сайн тооцоололд тулгуурлан хүлээн зөвшөөрдөг. Орлогын албан татварын тодорхой бус байдалтай холбоотой үүссэн залруулгыг орлогын албан татварын зардлын дансанд бүртгэдэг.

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ). Удирдлагын үнэлгээгээр Группийн санхүүгийн бус үйлчилгээний үйл ажиллагаанаас үүсэх НӨАТ-ын өр төлбөр байхгүй бөгөөд санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа (жишээлбэл, зээл олголт) нь Монгол Улсын Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын тухай хуулийн дагуу НӨАТ-аас чөлөөлөгддөг. Иймд Группийн зүгээс 2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар НӨАТ-д бүртгүүлээгүй байна.

Болзошгүй өр төлбөрт зориулсан нөөц. Энэ нь төлөх хугацаа болон дүн нь тодорхойгүй, санхүүгийн бус өр төлбөр юм. Группийн урьд нь тохиосон үйл явдлын үр дүнд одоо (эрх зүйн эсвэл үүсмэл) үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргийг биелүүлэхэд эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг гарган өгөх магадлалтай, мөн үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжтой тохиолдолд сан байгуулдаг.

Бусад өр төлбөрүүд. Бусад өр төлбөрийг харилцагч тал гэрээний дагуу өөрийн үүргийг биелүүлсэн тохиолдолд хуримтлуулж, хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Хүүгийн орлого ба зардлын хүлээн зөвшөөрөлт. Хүүгийн орлого, зардлыг бүх өрийн хэрэглүүрийн хувьд аккрузал сууриар үр ашигт хүүгийн аргаар бүртгэнэ. Энэ аргаар үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох гэрээний талуудын хооронд төлсөн буюу хүлээн авсан бүх төлбөрийг хүүгийн орлого, зардлын нэг хэсэг гэж үзэж хойшлуулж бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө үүсгэх буюу олж авах, санхүүгийн өр төлбөр гаргахтай холбоотой төлөгдсөн эсвэл хүлээн авсан төлбөр нь үр ашигт хүүгийн хувьтай холбоотой төлбөрт багтана, жишээ нь зээлжих чадварын үнэлгээний төлбөр, үнэлгээний болон бүртгэлийн хураамж гэх мэт. Зээл бүрийн олголтод ногдуулах ЛэндМН-ийн хураамж нь хүүгийн орлого гэж үзэхгүй боловч үр ашигт хүүний хувийн нэг хэсэгт тооцогдоно.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан, ХБЗА-ын загварт '3-р шатлал'-д ангилагдсан үед Компани хүүний орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн цэвэр хорогдуулсан өртөгт ЯАХА-ыг ашиглан тооцно. Хэрэв санхүүгийн хөрөнгийн чанар сайжирч үнэ цэнэ буурсан гэж тооцогдохоо больсон тохиолдолд хүүний орлогыг нийт дансны дүнд үндэслэн тооцох аргачлалд шилжинэ. Бусад бүх хураамж, шимтгэл болон бусад төрлийн орлого, зардлын зүйлсийг үйлчилгээний биелэлттэй уялдуулан, үйлчилгээг нийт шаардлагатай үйлчилгээний хэмжээнд харьцуулсан бодит биелэлтийн хувьтай дүйцүүлэн, хуримтлуулан бүртгэнэ.

Хувьцаат капитал болон нөөц. Энгийн хувьцааг эздийн өмчид тусгана. Шинээр энгийн хувьцаа гаргахтай шууд холбогдон гарсан нэмэгдэл зардлыг эздийн өмч хэсгийн энгийн хувьцааны сөрөг тохируулах данс байдлаар, татварын дараах цэвэр дүнгээр харуулна.

Группийн өөрийн гаргасан өмчийн хэрэглүүрийг дахин худалдан авсан тохиолдолд ("халаасны хувьцаа") өртгийн аргаар бүртгэн, эздийн өмчийн дүнгээс шууд хасна. Группийн өөрийн гаргасан өмчийн хэрэглүүрийг худалдаж авах, борлуулах, гаргах эсвэл хүчингүй болгох үед ашиг алдагдлын тайланд аливаа ашиг эсвэл алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв эдгээр хэрэглүүрийг дахин гаргавал, тэдгээрийн дансны дүн болон хүлээн авсан төлбөрийн зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэнэ.

Гадаад валютын хөрвүүлэлт. Группийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн үндсэн орчны мөнгөн тэмдэгт юм. Групп нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг тул бүртгэлийн болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг ("төг") юм. Гадаад валютаар бүртгэгдсэн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцэст Монгол банк ("МБ")-ны албан ханшаар Группийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн МБ-ны жилийн эцсийн албан ханш руу хөрвүүлснээс үүсэх гадаад валютын ханшийн олз, гарзыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх. Хэрэв Групп хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайланд толилуулах эрхтэй.

Сегментчилсэн тайлагнал. Сегментүүдийг Группийн үйл ажиллагааны гол шийдвэр гаргагчид зориулан дотоод тайлагналтай нийцүүлэн тайлагнана. Орлого, үр дүн эсвэл хөрөнгө нь нийт сегментүүдийн арван хувь буюу түүнээс дээш хувийг эзэлдэг сегментүүдийг тусад нь тайлагнана

Ажилтнуудтай холбоотой зардал болон холбогдох цалин хөлс. Цалин, хөлс болон бусад цалинтай холбоотой зардлыг Группийн тухайн тайлант хугацаанд зардалд хүлээн зөвшөөрнө. Жил тутмын цалинтай амралт зэрэг богино хугацааны хуримтлагдах цалинтай чөлөөг ажилтнуудад ирээдүйд цалинтай чөлөө авах эрх нь үүсгэх үед хүлээн зөвшөөрнө. Харин өвчтэй чөлөө зэрэг хуримтлагдахгүй богино хугацааны чөлөөг тухайн чөлөө гарсан үед хүлээн зөвшөөрнө. Монгол Улсын хуулийн дагуу бүх аж ахуйн нэгжүүд Төрийн тэтгэврийн тогтолцоо болох Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл төлөх үүрэгтэй. Эдгээр шимтгэлийг үүссэн үед нь ашиг буюу алдагдлын тайланд зардал болгон бүртгэнэ. Группийн зүгээс хууль тогтоомжид заасан хуримтлалын хэлбэрийн тэтгэврийн системд төлсөн шимтгэлээс цааш тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад тэтгэмж олгох хууль ёсны эсвэл бодит үүрэг байхгүй байна.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Хувьцаанд суурилсан төлбөр. АНД Глобал Пи Ти И Лтд. (Группийн толгой компани) нь Группийн гол ажилтнуудад өмчөөр тооцогдох хувьцаанд суурилсан төлбөрийг урамшууллаар олгосон. Ийм өмчөөр тооцогдох хэлцлийн бодит үнэ цэнийг олгох өдөр нь тодорхойлж, өмчлөх эрхийн олголтын хугацаанд шулуун шугамын аргаар ашиг буюу алдагдлын тайланд ажилтнуудтай холбоотой зардал болгон бүртгэх бөгөөд түүнд харгалзуулан өмчийн дүнг нэмэгдүүлнэ. Зах зээлээс хамаарахгүй эрх олголтын нөхцөлүүдийг хэдэн хувьцааны эрх олгогдохоор байгаа талаархи таамаглалд тусгана. Тайлагналын өдөр бүр эрх олгогдох магадлалтай хувьцааны опционуудын тооны үнэлгээг дахин хянаж шинэчилнэ. Энэхүү шинэчлэлээс үүдэн хийх бүх тохируулгыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрч, эздийн өмчийн харгалзах дансанд тохируулга хийнэ. Групп СТОУС 2-т заасан мөнгөн төлөлтөөр тооцдог хувьцаанд суурилсан төлбөрийн схем, эсвэл мөнгөн сонголттой хувьцаанд суурилсан төлбөрийн хэлцлийг хэрэгжүүлдэггүй.

Нэгж хувьцаанд ногдох ашиг. Үндсэн нэгж хувьцаанд ногдох ашгийг тайлант хугацаанд Группийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашгийг тухайн хугацаанд байгаа энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хувааж тооцно. Шингэрүүлсэн нэгж хувьцаанд ногдох ашгийг тайлант хугацаанд Группийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашгийг (хөрвөх давуу эрхтэй хувьцаа болон хөрвөх бондын хүүгийн зардлыг, татварын дараах дүнгээр нь тохируулсны дараа) тухайн хугацаанд байгаа энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо болон боломжит шингээлтийн нөлөө бүхий бүх энгийн хувьцаанууд хөрвөх тохиолдолд гарч ирэх энгийн хувьцааны жигнэсэн дундаж тооны нийлбэрт хувааж тооцно.

Холбоотой этгээдтэй хийсэн ажил гүйлгээ. Холбоотой этгээд гэдэг нь Групптэй дараах байдлаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. Үүнд:

(а) Хувь хүн эсхүл тухайн хүний ойрын гэр бүлийн гишүүн нь дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангаж байвал Группийн холбоотой этгээдэд тооцогдоно:

- Групп-д хяналт эсхүл хамтын хяналт хэрэгжүүлдэг;
- Групп-д мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг; эсвэл
- Группийн гол удирдах албан тушаалтнуудын нэг байдаг

(б) Хуулийн этгээд нь дараах нөхцөлүүдийн аль нэгийг нь хангаж байвал Группийн холбоотой этгээдэд тооцогдоно:

- Тухайн хуулийн этгээд болон Групп нь нэг групп компанийн бүрэлдэхүүнд багтаж байвал (Өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон толгой компанийн охин компаниуд холбогдох этгээдүүд юм.)
- Нэг этгээд нь нөгөө этгээдийн хараат компани эсхүл хамтарсан байгууллага байх (эсвэл нөгөө этгээд нь тухайн бүлгийн өөр гишүүний хараат компани эсвэл хамтарсан байгууллага байх).
- Хоёр этгээд хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан байгууллага байх.
- Нэг хуулийн этгээд нь гуравдагч хуулийн этгээдийн хамтарсан байгууллага, нөгөө этгээд нь түүнтэй холбоотой гуравдагч этгээдийн хараат компани байх.
- Тухайн хуулийн этгээд нь Группийн ажилчдад зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөө хэрэгжүүлдэг бол. Хэрэв Групп өөрөө ийм төлөвлөгөө болж байвал санхүүжүүлж буй ажил олгогч нь Группийн холбоотой этгээд болно.
- Тухайн этгээд нь (а) хэсэгт тодорхойлсон хүний хяналт дор эсхүл хамтын хяналттай байх.
- (а) хэсэгт тодорхойлсон хүн тухайн этгээдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг эсхүл тухайн этгээдийн (эсхүл түүний толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг байх.
- Тухайн этгээд эсвэл түүний харьяалагдах бүлгийн аливаа компани нь Группд эсвэл Группийн толгой компанид гол удирдах ажилтны үйлчилгээ үзүүлдэг бол.

Болзошгүй холбоотой этгээдийн харилцааг үнэлэхдээ зөвхөн эрх зүйн хэлбэрийг бус, харилцааны бодит мөн чанарыг харгалзан үзнэ. Холбоотой этгээдүүдтэй хийсэн бүх ач холбогдол бүхий гүйлгээ болон үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад толилуулсан бөгөөд Тодруулга 24 -өөс дэлгэрэнгүйг харна уу.

3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд

Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

2025 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон СТОУС 21-ийн 'Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө' стандартын өөрчлөлтүүдээс бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил байна.

Группийн үнэлгээгээр эдгээр нэмэлт өөрчлөлт нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөө байхгүй байна.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Группийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Групп нь эдгээр стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөж эхэлнэ.

СТОУС 9 болон СТОУС 7 нэмэлт өөрчлөлт	<i>Санхүүгийн хэрэглүүрийн ангилал ба хэмжилт ²</i>
СТОУС 18	<i>Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга²</i>

¹ 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ

² 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд группийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй юм.

4 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд

Групп нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүн болон дараагийн санхүүгийн жилд хүлээгдэж буй хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд нөлөөлөх тооцоолол, таамаглалуудыг гаргадаг. Эдгээр тооцоо болон мэргэжлийн дүгнэлтүүдийг удирдлагын туршлага, түүнчлэн тухайн нөхцөл байдалд нийцэхүйц ирээдүйн үйл явдлын талаарх хүлээлт зэрэг бусад хүчин зүйлд үндэслэн байнга үнэлж, шинэчилж байдаг. Удирдлага нь тооцооллоос гадна нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад тодорхой мэргэжлийн дүгнэлтүүдийг гаргадаг. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнд хамгийн ихээр нөлөөлдөг дүгнэлтүүд болон дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн балансласан дүнд мэдэгдэхүйц өөрчлөлт авчирч болзошгүй тооцооллууд нь дараах зүйлсийг багтаана:

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт. СТОУС 9-ийн дагуу санхүүгийн бүх төрлийн хөрөнгөнд үнэ цэнийн бууралтыг хэмжихдээ тодорхой үнэлэмж гаргах шаардлагатай. Ялангуяа ХБЗА-ыг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээ болон хугацааг тооцоолох, мөн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлэх нь чухал үнэлэмж шаардсан асуудлууд юм. Эдгээр тооцоолол, төсөөллүүдийн тодорхойгүй байдал нь ирээдүйд хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болно. Группийн ХБЗА-ын тооцоолол нь хувьсагч өгөгдлүүдийн сонголт болон тэдгээрийн харилцан хамаарлын талаарх олон суурь таамаглалд үндэслэсэн загварын үр дүн юм. ХБЗА-ын загварын хүрээнд нягтлан бодох бүртгэлийн дүгнэлт болон тооцоолол шаарддаг элементүүдэд дараах багтана:

- ХБЗА-ыг бүлгийн үнэлгээгээр тооцоологддог бол санхүүгийн хөрөнгийн сегментчилэл;
- ХБЗА-ын загваруудыг боловсруулах, мөн загварт ашиглах өгөгдлүүдийг сонгох;
- Макро эдийн засгийн хувилбарууд болон эдийн засгийн өгөгдлүүдийн хоорондын хамаарлыг тодорхойлох, мөн тэдгээрийн ТТБМ, ЧӨД and ЧМҮА-д үзүүлэх нөлөөллийг үнэлэх; болон
- ХБЗА-ын загварт оруулах макро эдийн засгийн урьдчилсан төлөвийн хувилбаруудыг сонгох, түүнчлэн эдгээр хувилбарын магадлалын жинг тодорхойлох

Группийн бодлого нь бодит алдагдлын туршлагатай уялдуулан ХБЗА-ын загваруудаа тогтмол хянан үнэлж, шаардлагатай үед тохируулга хийхэд чиглэдэг.

4 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд (Үргэлжлэл)

Удирдлага нь ирээдүйн мөнгөн урсгалыг төлөвлөхдөө зээлийн багцтай ижил зээлийн эрсдэлийн шинж чанартай, төлбөр төлөгдөхгүй байх магадлалтай хөрөнгийн түүхэн алдагдлын туршлагад үндэслэсэн тооцооллыг ашигладаг. Ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээ болон хугацааг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг алдагдал үүсэх магадлалын тооцоолол болон бодит алдагдлын хоорондын зөрүүг бууруулах зорилгоор тогтмол хянаж, шинэчилдэг.

5 Хүү болон түүнтэй адилтгах орлого ба сегментчлэлийн мэдээлэл

2025 болон 2024 оны 12 дугаар сарын 31-нд дууссан тайлант жилүүдэд Группийн үйл ажиллагаа нь нэг бизнесийн сегментэд хамаарч байсан бөгөөд энэ нь жижиг, дунд үйлдвэрлэлийн (ЖДҮ) эзэд зэрэг хувь хүн зээлдэгчдэд шуурхай зээл олгох үйл ажиллагаа юм (Тодруулга 12- оос дэлгэрэнгүйг үзнэ үү). Нөөц хуваарилалт болон гүйцэтгэлийн үнэлгээний зорилгоор Группийн үйл ажиллагааны гол шийдвэр гаргагчид хүргэгддэг мэдээлэл нь Группийн нөөцүүд харилцан нэгтгэгдсэн, тусдаа сегментийн санхүүгийн мэдээлэл байхгүй тул Группийн нийт үйл ажиллагааны үр дүнд төвлөрдөг. Иймд сегментийн мэдээллийг тусад нь тайлагнаагүй. Группийн гол үйл ажиллагаа болон харилцагчид Монгол Улсад байрладгаас шалтгаалан газарзүйн сегментийн нэмэлт мэдээлэл шаардлагагүй. 2025 болон 2024 онд Группийн орлогын 10 ба түүнээс дээш хувийг бүрдүүлсэн гадаад харилцагч байгаагүй.

	2025 Мян.төг	2024 Мян.төг
<i>Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого</i>		
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	134,759,217	88,635,336
Банкны харицах дансны хүүгийн орлого	212,805	385,560
Байгууллагын зээл	431,101	169,140
Нийт хүү болон түүнтэй адилтгах орлого	<u>135,403,123</u>	<u>89,190,036</u>
	2025 Мян.төг	2024 Мян.төг
<i>Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн зардал</i>		
Зээлээр авсан санхүүжилтын хүүгийн зардал	(36,411,279)	(21,064,144)
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн зардал	—	(788,160)
Түрээсийн өрийн хүүгийн зардал (Тод. 17)	(607,616)	(329,240)
Нийт хүүгийн зардал ба түүнтэй адилтгах зардал	<u>(37,018,895)</u>	<u>(22,181,544)</u>

6 Хүлээгдэж буй зээлийн эрсдлийн сангийн зардал

Доорх хүснэгтэнд ашиг алдагдалд тайланд бүртгэсэн санхүүгийн хөрөнгө дэх үнэ цэнийн бууралтыг харуулав.

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанд тооцсон хүлээгдэж буй зээлийн эрсдлийн алдагдал (Тод. 12.1)	31,557,683	8,157,556
Ирээдүйд харилцагчдад олгохоор тооцсон зээлийн хүлээгдэж буй зээлийн эрсдлийн алдагдал (Тод. 19)	71,680	41,106
	<u>31,629,363</u>	<u>8,198,662</u>

7 Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал

	2025	2024
	Мян.төг	Мян.төг
Цалин хөлс ба урамшуулал	6,447,027	4,385,839
ЛэндМН техник үйлчилгээний зардал (Тод. 24)	3,273,031	2,123,539
Мэргэжлийн үйлчилгээний зардал	2,768,406	2,651,655
Үйл ажиллагааны бусад зардал	1,472,379	1,107,689
Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал (Тод. 16 болон 17)	1,089,836	831,083
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	754,430	498,479
Маркетингийн зардал	725,641	437,864
Банкны шимтгэл	320,472	175,056
Засвар, үйлчилгээний зардал	102,969	62,166
Биет бус хөрөнгийн хорогдуулалт (Тод. 15)	96,901	45,383
	17,051,092	12,318,753

8 Бусад орлого/(зардал), цэвэр

	2025	2024
	Мян.төг	Мян.төг
<i>Бусад орлого/(зардал), цэвэр:</i>		
Ногдол ашгийн орлого	59,183	—
Эрсдэлийн сангаас хаасан зээлийн эргэн төлөлт	265,497	209,741
Түрээс данснаас хассаны олз (Тод. 16)	99,013	—
Ашиг, алдагдлаарх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз (Тод. 13.1)	245,079	89,889
Үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз (Тод. 13.2)	340,041	—
Гадаад валютын ханшийн хэрэгжсэн олз/(гарз), цэвэр	(763,119)	88,489
Бусад орлого	31,574	36,748
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас данснаас хассаны гарз (Тод. 14)	—	(15,580)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тод. 16)	(799)	(29,418)
Гадаад валютын ханшийн хэрэгжээгүй олз(гарз), цэвэр	(66,022)	(299,310)
Бусад зардал	(950,017)	(444,376)
	(739,570)	(363,817)

9 Орлогын албан татвар

9.1 Орлогын албан татварын зардал

Орлогын албан татварын зардал нь дараахаас бүрдэнэ:

	2025	2024
	Мян.төг	Мян.төг
Орлогын албан татвар:		
Тайлант жилийн орлогын албан татвар (Тод. 9.2)	9,788,105	10,168,629
Өмнөх тайлант жилийн орлогын албан татвартай холбоотой залруулга	(990,537)	(26,091)
Хойшлогдсон татвар:		
Татварын түр зөрүү	87,693	(128,927)
	8,885,261	10,013,611

Групп компани нь татварын зорилгоор хасагдахгүй зардлуудыг санхүүгийн тайлагналын зорилгоор хүлээн зөвшөөрдөг. Группийн цэвэр ашгаас татвар суутгах хувь нь Монгол Улсын хуулийн дагуу 6 тэрбум хүртэлх дүнд (2024: 6 тэрбум төгрөг) 10% (2024:10%), түүнээс дээшхи татвар ногдуулах орлогод 25%-ийг (2024: 25%) суутгана.

9.1 Орлогын албан татварын зардал (Үргэлжлэл)

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Группийн үр ашигт татварын хувиар тооцож гаргасан орлогын албан татварын зардалд 2025 болон 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Татварын өмнөх ашиг	48,964,203	46,127,260
25%-ийн орлогын албан татвар (2024: 25%)	12,257,235	11,681,815
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	700,429	654,509
Татварын бага хувь хэмжээ ба татварын шатлалд хамаарах орлогын нөлөө	(730,425)	(1,097,134)
Тайлант жилийн орлогын албан татварын хөнгөлөлт	(2,351,441)	(1,199,488)
Өмнөх тайлант жилийн орлогын албан татвартай холбоотой залруулга	(990,537)	(26,091)
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	<u>8,885,261</u>	<u>10,013,611</u>

Групп компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх орлогын албан татварын хувь: 18.5% (2024: 21.7%).

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар “Компанийн тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн дагуу Групп татварын хөнгөлөлт хүлээн зөвшөөрсөн.

9.2 Орлогын албан татварын өр төлбөр/(авлага)

	2025 Мян.төг	2024 Мян.төг
1 сарын 1-ний орлогын албан татварын өр төлбөр	3,566,405	3,638,541
Охин компанийг үл хүлээн зөвшөөрөлттэй холбоотой хасагдуулга	(494)	—
Тайлант үеийн орлогын албан татварын зардал (Тод 9.1)	9,788,105	10,142,538
Өмнөх тайлант жилийн орлогын албан татвартай холбоотой залруулга	(990,537)	—
Төлсөн татвар	(12,533,591)	(10,115,736)
Суутгуулсан татвар	<u>(17,182)</u>	<u>(98,938)</u>
12 сарын 31-ний орлогын албан татварын өр төлбөр/(авлага)	<u>(187,294)</u>	<u>3,566,405</u>

9.3 Хойшлогдсон татварын (хөрөнгө)/өр төлбөр

Хойшлогдсон татварын (хөрөнгө)/өр төлбөр нь дараах байдалтай байна:

	Эхний үлдэгдэл Мян.төг	Ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн Мян.төг (Тод. 9.1)	Эцсийн үлдэгдэл Мян.төг
2025			
Хойшлогдсон татварын хөрөнгө:			
Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өглөг	44,804	55,221	100,025
Хуримтлуулсан цалингийн зардал	74,635	(2,308)	72,327
Үндсэн хөрөнгийн элэгдэл	15,588	(851)	14,737
Хэрэгжээгүй ханшийн алдагдал	45,950	(30,689)	15,261
	<u>180,977</u>	<u>21,373</u>	<u>202,350</u>
Хойшлогдсон татварын өр төлбөр:			
Ашиг, алдагдлаарх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	–	(74,809)	(74,809)
Үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(19,776)	(43,636)	(63,412)
	<u>(19,776)</u>	<u>(118,445)</u>	<u>(138,221)</u>
Цэвэр хойшлогдсон татварын хөрөнгө	<u>161,201</u>	<u>(97,072)</u>	<u>64,129</u>
2024			
Хойшлогдсон татварын хөрөнгө:			
Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өглөг	3,599	41,205	44,804
Хуримтлуулсан цалингийн зардал	34,653	39,982	74,635
Үндсэн хөрөнгийн элэгдэл	3,067	12,521	15,588
Хэрэгжээгүй ханшийн алдагдал	–	45,950	45,950
	<u>41,319</u>	<u>139,658</u>	<u>180,977</u>
Хойшлогдсон татварын өр төлбөр:			
Хэрэгжээгүй ханшийн алдагдал	(9,045)	9,045	–
Ашиг, алдагдлаарх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	–	(19,776)	(19,776)
	<u>(9,045)</u>	<u>(10,731)</u>	<u>(19,776)</u>
Цэвэр хойшлогдсон татварын хөрөнгө	<u>32,274</u>	<u>128,927</u>	<u>161,201</u>

10 Нэгж хувьцаанд ногдох ашиг

Группд шингэрүүлэх боломжтой энгийн хувьцаа байхгүй учир нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн нэгж хувьцаанд ногдох ашгийн дүн тэнцүү болно.

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Эздэд ногдох бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх тайлант жилийн цэвэр ашиг	40,078,942	36,113,649
Шингэрүүлсэн нэгж хувьцаанд ногдох ашиг дахь хувьцааны жигнэсэн дундаж тоо	739,301,683	739,301,683
	2025 Мян.төг	2024 Мян.төг
Өмч эзэмшигчид:		
Шингэрүүлсэн нэгж хувьцаанд ногдох ашиг	54.21	48.85

11 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Бэлэн мөнгө	310	878
Банкинд байршуулсан хөрөнгө	16,314,907	12,705,196
	<u>16,315,217</u>	<u>12,706,074</u>

Банкинд байршуулсан мөнгө нь Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй банк болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах болон богино хугацаат хадгаламжийн данснаас бүрдэх ба барьцаагүй. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнээрх дүнтэйгээ ойролцоо байдаг. Харилцах данс нь 0.0%-2.0%-н хүүний түвшинд байршуулагдсан байна.

Групп нь 2025 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар СТОУС 9-ийн дагуу мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалд өртөх магадлалыг тооцоолсон. Мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн ихэнх нь шаардлагатай үед шууд ашиглах боломжтой тул хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг материаллаг нөлөөгүй гэж үнэлсэн. Иймд Групп нь 2025 болон 2024 онд дуусгавар болсон санхүүгийн тайландаа мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг бүртгээгүй.

12 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа

	2025 Мян.төг	2024 Мян.төг
ЛэндМН системээр олгосон зээл		
Хэрэглээний зээл	205,292,774	183,779,291
Бизнесийн зээл	128,098,077	56,594,233
Байгууллагын зээл	1,260,243	1,573,762
Автомашинны зээл	1,638,057	2,973,484
Нийт харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	<u>336,289,151</u>	<u>244,920,770</u>
Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан	<u>(28,579,270)</u>	<u>(13,193,203)</u>
Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн цэвэр зээл болон урьдчилгаа	<u>307,709,881</u>	<u>231,727,567</u>

Группийн бизнесийн онцлогоос шалтгаалан ЛэндМН аппликэйшнийг ашигладаг зээлдэгчдийн ихэнх нь хувь хүмүүс бөгөөд богино болон дунд хугацааны санхүүгийн хэрэгцээгээ хангах зорилгоор зээл авдаг.

2021 оноос эхлэн Группийн ЛэндМН аппликэйшнд зээлийн түүх нь шаардлага хангаж байгаа зээлдэгчдэд автомашины зээлийг олгож эхэлсэн. Автомашины зээл нь зээлдэгчийн худалдан авсан автомашиныг барьцаалдаг.

2023 оны 4 дүгээр сараас Групп нь 5 сая төгрөгөөс 50 сая төгрөгийн хүртэлх зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлсэн. Уг бүтээгдэхүүн нь харилцагчдын дунд хугацааны санхүүгийн хэрэгцээг санхүүжүүлэх зорилготой ба зээлдэгчийн сүүлийн 2 жилийн зээлийн түүх нь шаардлага хангасан байх шаардлагатай.

Групп 2024 оны 2-р сард ЖДҮ эрхлэгчдэд тусгайлан зориулсан бизнесийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргасан ба уг зээлийн бүтээгдэхүүн нь 5 сая төгрөгөөс 100 сая төгрөг хүртэлх зээлийн уян хатан нөхцөлөөр бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээг хангах зорилготой юм. Зээлдэгчдэд тавигдах шалгуур нь бусад зээлд тавигдах шалгууртай адил байна.

12 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа (Үргэлжлэл)

Группийн зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС 9-ийн дагуу бүртгэдэг. Ерөнхий аргачлалын дагуу Группийн зээлийн багцыг шатлал 1, шатлал 2 болон шатлал 3 гэсэн ангилалд хувааж, шатлал бүрт ирээдүйн хүлээгдэж буй эрсдлийн төсөөлөлд суурилсан алдагдлын хувийг ТТБМ болон ЧМҮА жинлэсэн дундаж аргачлалаар тооцдог. Үнэ цэнийн бууралттай холбоотой бодлого болон тооцооллын дэлгэрэнгүйг 21.3 дугаар тодруулгад толилуулсан болно.

Шатлал 1: + 31 хоногоос бага хугацаа хэтэрсэн зээлийн багц

Шатлал 2: 31–90 хоногоор хугацаа хэтэрсэн зээлийн багц

Шатлал 3: 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийн багц

12.1 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт

Нийт зээлийн багцын зээлжих чанарыг дараах байдлаар харуулав:

	Шатлал 1 Мян.төг	Шатлал 2 Мян.төг	Шатлал 3 Мян.төг	Нийт дүн Мян.төг
2025 оны 12 сарын 31- нээр				
Хэвийн зээл	294,038,608	1,208,589	–	295,247,197
Хугацаа хэтэрсэн зээл	–	10,374,903	30,667,051	41,041,954
Нийт дүн	<u>294,038,608</u>	<u>11,583,492</u>	<u>30,667,051</u>	<u>336,289,151</u>
2024 оны 12 сарын 31- нээр				
Хэвийн	225,883,058	–	–	225,883,058
Хугацаа хэтэрсэн зээл	–	6,604,329	12,433,383	19,037,712
Нийт дүн	<u>225,883,058</u>	<u>6,604,329</u>	<u>12,433,383</u>	<u>244,920,770</u>

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны нийт дүн болон түүнд хамаарах хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХБЗА) нь дараах байдалтай байна:

	Шатлал 1 Мян.төг	Шатлал 2 Мян.төг	Шатлал 3 Мян.төг	Нийт дүн Мян.төг
2025 оны 1 сарын 1-нээр	225,883,058	6,604,329	12,433,383	244,920,770
Шинээр олгосон эсвэл худалдан авсан	1,268,134,952	–	–	1,268,134,952
Эргэн төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(1,142,164,218)	(10,053,453)	(8,377,284)	(1,160,594,955)
Шатлал 2-руу шилжсэн	(57,815,184)	57,815,184	–	–
Шатлал 3-руу шилжсэн	–	(42,782,568)	42,782,568	–
Сангаас хаасан	–	–	(16,171,616)	(16,171,616)
2025 оны 12 сарын 31- нээр	<u>294,038,608</u>	<u>11,583,492</u>	<u>30,667,051</u>	<u>336,289,151</u>
2024 оны 1 сарын 1-нээр	119,732,242	3,751,139	5,645,914	129,129,295
Шинээр олгосон эсвэл худалдан авсан	1,019,732,223	–	–	1,019,732,223
Эргэн төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(897,241,040)	(5,967,059)	(101,374)	(903,309,473)
Шатлал 2-руу шилжсэн	(16,340,367)	16,340,367	–	–
Шатлал 3-руу шилжсэн	–	(7,520,118)	7,520,118	–
Сангаас хаасан	–	–	(631,275)	(631,275)
2024 оны 12 сарын 31- нээр	<u>225,883,058</u>	<u>6,604,329</u>	<u>12,433,383</u>	<u>244,920,770</u>

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга- 2025 оны 12 сарын 31

12 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа (Үргэлжлэл)

12.1 Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)

2025 оны 1 сарын 1-нээрх ХБЗА-н сан:	3,809,056	2,710,303	6,673,844	13,193,203
Шинээр олгосон эсвэл худалдаж авсан	26,655,480	–	–	26,655,480
Эргэн төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(24,007,646)	(2,261,375)	(6,284,463)	(32,553,484)
Шатлал 2-руу шилжсэн	(1,215,243)	1,215,243	–	–
Шатлал 3-руу шилжсэн	–	(9,623,305)	9,623,305	–
Шатлал хооронд шилжилтийн ХБЗА-д үзүүлсэн нөлөө		11,789,426	22,471,284	34,260,710
Тооцооллын өгөгдлийн өөрчлөлт ХБЗА-д үзүүлэх нөлөө	(516,681)	(1,212,744)	4,924,402	3,194,977
Тайлант хугацааны нэмэгдэл (Тод. 6)	915,910	(92,755)	30,734,528	31,557,683
Сангаас хаасан	–	–	(16,171,616)	(16,171,616)
2025 оны 12 сарын 31-нээр	<u>4,724,966</u>	<u>2,617,548</u>	<u>21,236,756</u>	<u>28,579,270</u>
2024 оны 1 сарын 1-нээрх ХБЗА-н сан:	1,768,089	1,477,051	2,421,782	5,666,922
Шинээр олгосон эсвэл худалдаж авсан	15,466,331	–	–	15,466,331
Эргэн төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(8,869,600)	(2,328,482)	(54,783)	(11,252,865)
Шатлал 2-руу шилжсэн	(247,835)	247,835	–	–
Шатлал 3-руу шилжсэн	–	(3,212,456)	3,212,456	–
Шатлал хооронд шилжилтийн ХБЗА-д үзүүлсэн нөлөө	(4,307,929)	6,526,355	1,725,664	3,944,090
Тайлант хугацааны нэмэгдэл (Тод. 6)	2,040,967	1,233,252	4,883,337	8,157,556
Сангаас хаасан	–	–	(631,275)	(631,275)
2024 оны 12 сарын 31-нээр	<u>3,809,056</u>	<u>2,710,303</u>	<u>6,673,844</u>	<u>13,193,203</u>

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдаглын сангийн хөдөлгөөн:

	2025 Мян.төг	2024 Мян.төг
1 сарын 1-нээр	13,193,203	5,666,922
Тайлант хугацааны нэмэгдэл (Тод. 6)	31,557,683	8,157,556
Тайлант хугацаанд сангаас хаасан	(16,171,616)	(631,275)
12 сарын 31-нээр	<u>28,579,270</u>	<u>13,193,203</u>

13 Санхүүгийн хэрэглүүр

13.1 Санхүүгийн хэрэглүүр

	2025 Мян.төг	2024 Мян.төг
1 сарын 1-нээр	1,094,548	1,004,659
Ашиг, алдагдлаарх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз (Тод 8)	245,079	89,889
12 сарын 31-нээр	1,339,627	1,094,548

13.2 Үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Доорх хүснэгтэнд хөрөнгө болон өр төлбөрөөр бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамтаар харууллаа. Нэрлэсэн үнэ нь санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсхүл индекс байх бөгөөд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсхүл зээлийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

Своп	Нэрлэсэн дүн Мян.доллар	Нэрлэсэн дүн Мян.төг	Бодит үнэ цэнэ		
			Хөрөнгө Мян.төг	Өр төлбөр Мян.төг	Цэвэр дүн Мян.төг
2025	20,000	71,224,500	612,210	272,169	340,041
2024	—	—	—	—	—

2025 оны 4 болон 10 дугаар саруудад Групп холбоотой талаас авсан 20 сая ам.долларын зээлтэй холбоотой валютын ханшийн эрсдэлийг хедж хийх зорилгоор “Эм ЭФ Экс Сольюшнс” ХХК-тай валют солилцох-хүүгийн своп (ВСХС) гэрээ байгуулсан. ВСХС гэрээний нөхцөлийн дагуу Группийн төгрөгт суурилсан хэсэгт 7.28%-аас 8.00% хүртэлх тогтмол хүү төлөх, доллард суурилсан хэсэгт 0.00%-ийн тогтмол хүү хүлээн авах зохицуулалттай. Эдгээр своп гэрээний хугацаа 2028 оны 4 дүгээр сард дуусгавар болно.

ВСХС гэрээний хавсралтын дагуу Групп 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар “Эм ЭФ Экс Сольюшнс” ХХК-д 1,420 мянган ам.доллар буюу 5,050,457 мянган төгрөгийн мөнгөн барьцааг байршуулсан (Тодруулга 13-ыг үзнэ үү). Барьцаанд байршуулсан хөрөнгөнөөс АНУ-ын холбооны сангийн хүүгийн түвшнээс (Н.15 Блүүмбэргт нийтлэгддэг) 50 суурь оноо хассантай тэнцэх хүүг олдог бөгөөд үүнийг ашиг, алдагдлын тайланд хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрдөг.

Группийн үүсмэл гэрээнүүдийн хүрээнд хүлээгдэж буй эрсдэлийг зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд тасралтгүй хянаж байдаг. Эрсдэлийн удирдлагын стратеги болон эрсдэлийг хэрхэн удирддаг талаархи мэдээллийг Тодруулга 21-ээс харна уу.

14 Бусад хөрөнгө

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Бусад авлага	2,171,563	537,936
Үүсмэл санхүүгийн хөрөнгөтэй холбоотой барьцаа хөрөнгө (Тод. 13.2)	5,050,457	—
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	—	11,000
Хангамжийн материал	3,320	4,116
Урьдчилж төлсөн зардал	917,077	391,103
	8,142,417	944,155

14 Бусад хөрөнгө (Үргэлжлэл)

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг дараах байдлаар харуулав:

	2025	2024
	Мян.төг	Мян.төг
1 сарын 1-нээр	11,000	15,080
Буцаан авсан	–	100,000
Борлуулсан	–	(104,080)
Үндсэн хөрөнгө рүү ангилсан (Тод. 15)	(11,000)	–
12 сарын 31-нээр	<u>–</u>	<u>11,000</u>

Бусад авлага нь барьцаагүй бөгөөд хугацаагүй. Бусад авлагын төлбөр төлөгдөх магадлалыг харилцагчийн төлбөрийн чадварыг харгалзан үнэлсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжээг ач холбогдолгүй гэж үзсэн.

Тайлант жилд барьцаанд хураагдсан автомашины борлуулалтын орлого 2025 онд тэг төгрөг (2024 он: 88,500 мянган төгрөг) байсан бөгөөд автомашины борлуулалтын алдагдал 2025 онд тэг төгрөг (2024 он: 15,580 мянган төгрөг) байсан (Тодруулга 8-ыг үзнэ үү).

15 Биет бус хөрөнгө

	2025	2024
	Мян.төг	Мян.төг
Өртөг		
1 сарын 1-нээр	1,055,332	610,818
Нэмэгдсэн	637,755	444,514
Охин компани авахтай холбогдуулан нэмэгдсэн	273,565	–
12 сарын 31-нээр	<u>1,966,652</u>	<u>1,055,332</u>
Хуримтлагдсан хорогдуулалт		
1 сарын 1-нээр	300,659	255,276
Тайлант жилд байгуулсан (Тод. 7)	96,901	45,383
Охин компани авахтай холбогдуулан нэмэгдсэн	184,912	–
12 сарын 31-нээр	<u>582,472</u>	<u>300,659</u>
Цэвэр дансны үнэ	<u>1,384,180</u>	<u>754,673</u>

Группийн биет бус хөрөнгө нь “АНД Системс Тех” ХХК-иас (холбоо хамааралтай компани) худалдан авсан Монгол Улсын нутаг дэвсгэрт зээл болон хэтэвчийн үйл ажиллагаа явуулах онцгой эрхийн лицензтэй ЛэндМН системээс бүрдэнэ. Зээлийн үйл ажиллагаанд ашиглагддаг аппликэйшн буюу платформыг анх 2016 оны 12 сард “АНД Системс Тех” ХХК-иас худалдан авсан бөгөөд уг платформ нь хэрэглэгч бүртгэх, зээлийн эрх тооцоолох, банкны систем, хэрэглэгчийн үйлчилгээ болон тайлагналын модулиуд, мөн ЛэндМН аппликэйшнийг агуулдаг. ЛэндМН системийн ашиглах онцгой эрхийн нэг удаагийн лицензийн төлбөр нь 300,000 мянган төгрөг.

Лицензийн гэрээ нь харилцан тохиролцоогүй тохиолдолд, эсвэл группийн зээл олголтын тусгай зөвшөөрөл хүчингүй болох хүртэл цуцлагдах боломжгүй. Лицензийн хорогдуулах хугацаа 50 жилээр тогтоогдсон боловч компани ЛэндМН системийн ашиглалтын хугацааг бодитой үнэлгээнд үндэслэн 10 жилийн хугацаанд хорогдуулахаар тооцсон.

15 Биет бус хөрөнгө (Үргэлжлэл)

2021 оны 8 дугаар сард Групп Компани Сингапур улсад байршилтай холбоо хамааралтай компани болох “АНД Сольюшн” ХХК-тай ЛэндМН системийг ЛэндМН 2.0 хувилбар болгож шинэчлэх гэрээ байгуулсан бөгөөд шинэчилсний өртөг нь 300,042 мянган төгрөг байсан. ЛэндМН 2.0 хувилбарт 10 жилээр хорогдуулалт тооцдог. Үүнтэй адил, 2025 болон 2024 онуудад компани зээл олголтын аппликэйшн болон “Плас” аппликэйшний нэмэлт сайжруулалтад зориулж 637,755 мянган төгрөгийг төлсөн (2024 он: 231,396 мянган төгрөг болон 213,118 мянган төгрөг). Энэ шинэчлэлийг мөн 10 жилийн хугацаанд хорогдуулна.

16 Үндсэн хөрөнгө

	Тавилга эд хогшил Мян.төг	Компьютер, дагалдах хэрэгсэл Мян.төг	Түрээсийн байрны сайжруулалт Мян.төг	Нийт хөрөнгө Мян.төг
Өртөг				
2025 оны 1 сарын 1-нээр	373,494	562,178	1,005,132	1,940,804
Нэмэгдсэн	322,528	156,299	287,113	765,940
Дахин ангилсан (Тод. 13)	11,000	—	—	11,000
Данснаас хассан (Тод. 8)	(620)	(25,847)	—	(26,467)
Охин компани олж авахтай холбогдуулан нэмэгдсэн	116,494	10,409	—	126,903
2025 оны 12-р сарын 31	822,896	703,039	1,292,245	2,818,180
Хуримтлагдсан элэгдэл				
2025 оны 1-р сарын 1-нээр	84,769	345,905	—	430,674
Тайлант жилд байгуулсан (Тод. 7)	49,948	121,389	183,860	355,197
Данснаас хассан (Тод. 8)	(537)	(25,131)	—	(25,668)
Охин компани олж авахтай холбогдуулан нэмэгдсэн	67,342	6,566	—	71,771
2025 оны 12-р сарын 31	201,522	448,729	183,860	834,111
Цэвэр дансны дүн	621,374	254,310	1,108,385	1,984,069
Өртөг				
2024 оны 1-р сарын 1-нээр	276,211	423,981	214,080	914,272
Нэмэгдсэн	188,835	189,879	1,009,717	1,388,431
Акталсан (Тод. 8)	(45,955)	(51,682)	(218,665)	(316,302)
Данснаас хассан	(45,597)	—	—	(45,597)
2024 оны 12-р сарын 31	373,494	562,178	1,005,132	1,940,804
Хуримтлагдсан элэгдэл				
2024 оны 1-р сарын 1-нээр	94,676	304,948	208,490	608,114
Тайлант жилийн нэмэгдэл (Тод. 7)	31,537	91,709	10,175	133,421
Акталсан (Тод. 8)	(17,467)	(50,752)	(218,665)	(286,884)
Данснаас хассан	(23,977)	—	—	(23,977)
2024 оны 12-р сарын 31	84,769	345,905	—	430,674
Цэвэр дансны үнэ	288,725	216,273	1,005,132	1,510,130

Тайлант хугацаанд Групп 799 мянган төгрөгийн дансны үнэтэй компьютер болон дагалдах хэрэгсэл данснаас хассан (2024 он: 21,620 мянган төгрөг) бөгөөд 799 мянган төгрөгийн алдагдал хүлээн зөвшөөрсөн.

17 Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр

Групп хэд хэдэн барилгын оффисын талбай болон зогсоолыг 1-ээс 5 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулсан.

Группийн түрээсийн гэрээний хүрээнд хүлээсэн үүрэг нь түрээслүүлэгчийн түрээслүүлсэн хөрөнгийн өмчлөх эрхээр баталгааждаг. Мөн түүнчлэн Групп түрээслүүлэгчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр түрээслэгдсэн хөрөнгийг шилжүүлэх буюу дахин түрээслүүлэхийг хориглодог.

Групп 12 сараас бага хугацаатайгаар автомашины зогсоолын түрээсийн гэрээ болон бага үнийн дүнтэй оффисын тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээнүүд хийгдсэн. Групп ийм түрээсийг 'богино хугацаат түрээс' болон 'бага үнэ бүхий хөрөнгийн түрээс' гэж хүлээн зөвшөөрдөг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг доорх байдлаар харуулав:

	2025	2024
	Мян.төг	Мян.төг
1 сарын 1-нээр	3,432,748	945,652
Нэмэгдсэн	—	3,448,589
Тайлант хугацаанд байгуулсан элэгдэл (Тод. 7)	(734,639)	(697,662)
Хугацаанаас өмнө цуцалсан	(427,492)	(263,831)
12 сарын 31-нээр	<u>2,270,617</u>	<u>3,432,748</u>

Түрээсийн өр төлбөрийг доорх байдлаар харуулав:

	2025	2024
	Мян.төг	Мян.төг
1 сарын 1-нээр	3,636,405	981,642
Нэмэгдсэн	—	3,448,589
Хуримтлагдсан хүү (Тод 5)	607,616	329,240
Түрээсийн төлбөр	(955,745)	(859,235)
Хугацаанаас өмнө цуцалсан	(526,505)	(263,831)
12 сарын 31-нээр	<u>2,761,771</u>	<u>3,636,405</u>
Богино хугацаат түрээсийн өр төлбөр	562,321	379,159
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	2,199,450	3,257,246

Компани "Сувд" барилгын 1 давхарын түрээсийн гэрээг цуцлах үед 99,013 мянган төгрөгийн олз (Тод 8) хүлээн зөвшөөрсөн. Уг гэрээг цуцлах үед ашиглах эрхтэй хөрөнгө нь 427,492 мянган төгрөг, түрээсийн өр төлбөр нь 526,505 мянган төгрөг байсан.

18 Зээлээр авсан санхүүжилт

		2025	2024
		Мян.төг	Мян.төг
Бонд	(i)	21,029,727	29,028,833
Зээл	(ii)	141,749,091	78,274,912
Итгэлцлийн өглөг	(iii)	67,337,304	62,629,632
		<u>230,116,122</u>	<u>169,933,377</u>

- i. 2024 онд Групп 200,000 ширхэг бонд гаргасан бөгөөд тус бүрийн нэрлэсэн үнэ 100,000 төгрөг, жилийн хүү 18.0%-18.5% бүхий 10 хэсэгт хуваагдсан байна. 2025 оны байдлаар гаргасан нийт 200,000 бондын 5,000 ширхэгийн хугацаа дууссан байна.

2025 онд групп 60,000 ширхэг хаалттай бонд гаргасан бөгөөд нэгж бондын нэрлэсэн үнэ нь 100,000 төгрөг бөгөөд жилийн хүүгийн хувь 12.0%-18.5% хооронд хэлбэлзэж, 2026 онд хугацаа нь дуусах 2 хэсэгт хуваагдсан бүтэцтэй байна.

18 Зээлээр авсан санхүүжилт (Үргэлжлэл)

- ii. 2021 онд групп толгой компани болох АНД Системс ХХК-аас 2,845,000 мянган төгрөгийн жилийн 14%-ийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, хагас жил тутам хүү төлөх нөхцөлтэй зээл авсан.

2024 оны 10-р сард групп АНД Системс ХХК-аас нийт 20,000,000 мянган төгрөгийн жилийн 19%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай зээл авсан. 2025 ны 10-р сард энэ зээлийн шугамын нөхцөлийг өөрчилж, хугацааг 2026 оны 10-р сар хүртэл сунгасан.

2023 оны 10-р сард групп АНД Системс ХХК-аас 3,000 мянган ам.долларын жилийн 12.0%-ийн хүүтэй, 2 жилийн хугацаатай зээл авсан. 2025 оны 10-р сард энэ зээлийн шугамын нөхцөлийг өөрчилж, хугацааг 2026 оны 10-р сар хүртэл сунгасан. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар энэ зээлийн шугамаас 2,400 мянган ам.доллар татагдсан байна.

2025 оны 4-р сарын 7-нд Группийн толгой холдинг компани болох АНД ФСЖ Пти Лтд-тэй нийт 20,000 мянган ам.долларын зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулсан бөгөөд уг санхүүжилт нь 2 хэсгээс бүрдсэн. Эхний зээлийн хэмжээ болох 10,000 мянган ам.доллар нь 2025 ны 4-р сард, хоёр дахь 10,000 мянган ам.долларын зээл нь 2025 оны 10-р сард тус тус олгогдсон. Эдгээр зээл нь SOFR-д суурилсан хөвөгч хүүтэй бөгөөд жилийн 15.0%-ийн эхлэх хүүтэй, 14%-ийн доод хягаартай, 16.0%-ийн дээд хязгаартай бөгөөд хүүг улирал тутам төлнө. Зээлийн хугацаа нь гурван жил бөгөөд тогтмол бус хорогдуулалттай. Эдгээр зээлийн барьцаанд 28,755 мянган ам.долларын дансны үнэтэй зээл болон урьдчилгаа багтсан. Уг санхүүжилтийн бүтэц нь цувуулан төлөх хэлбэрийн санхүүжилт бөгөөд толгой холдинг компани Лэндэбл Ассет Менежмент ХХК-аас босгосон санхүүжилтийг группд дахин зээлдүүлсэн. Энэхүү санхүүжилтийн хүрээнд группийн гадаад валютын эрсдэлийг бууруулах зорилгоор МФХ сольюшнс ХХК-тай валютын свопын гэрээ байгуулсан (Тодруулга 13).

2025 онд Групп Алт инком инвестмэнт Пти Лтд-тэй нийт 4,000 мянган ам.долларын зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулсан бөгөөд уг санхүүжилт нь дөрвөн хэсгээс бүрдсэн. Зээлүүд нь жилийн 12.5%-аас 13.0% хүртэлх хүүтэй, улирал тутам хүүгийн төлбөр төлөгдөх нөхцөлтэй бөгөөд гурван жилийн хугацаатай, үндсэн төлбөр нь хугацааны эцэст нэг удаагийн төлөлттэй байна. Уг зээлээрх санхүүжилт нь 5,841 мянган ам.долларын дансны үнэтэй зээл, авлагаар барьцаалагдсан.

2025 оны 12 дугаар сарын 2-нд Групп ДВМ Инком сантай нийт 2,450 мянган ам.долларын зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулсан бөгөөд уг санхүүжилт нь гурван хэсгээс бүрдсэн. Эхний хэсэг болох 820 мянган ам.долларын зээл нь 2025 оны 12 дугаар сарын 15-нд олгогдсон. Зээлүүд нь жилийн 12.0%-ийн тогтмол хүүтэй, хүүг хагас жил тутам төлөх нөхцөлтэй бөгөөд гурван жилийн хугацаатай, тогтмол бус үндсэн төлөлттэй. Эхний хэсэг нь 1,212 мянган ам.долларын дансны үнэтэй зээл ба урьдчилгаагаар барьцаалагдсан. Эхний хэсэг нь жилийн эцэст олгогдсон бөгөөд хоёр дахь болон гурав дахь хэсгүүдийг 2026 онд олгохоор төлөвлөсөн.

2025 оны 12 дугаар сарын 15-нд Компаникомпани болох АНД Системс ХХК-тай зээлийн гэрээ байгуулж, нийт 3,000 мянган ам.долларын зээл авсан. Зээл нь SOFR-т суурилсан хөвөгч хүү дээр 17.76%-ийн нэмэгдэлтэй бөгөөд хүүг хагас жил тутам төлөх нөхцөлтэй. Зээлийн хугацаа таван жилээр тодорхойлогдсон 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группд дотоодын арилжааны банкнаас авсан 6,000,000 мянган төгрөгийн үлдэгдэл зээл байсан бөгөөд жилийн 19%-ийн хүүтэй, 2026 оны 4 дүгээр сард хугацаа нь дуусахаар байсан. Уг зээл нь 8,000,000 мянган төгрөгийн банкны хадгаламжаар барьцаалагдсан.

Мөн Компанид жилийн эцэст 2,200,000 мянган төгрөгийн (2024: 2,000,000 мянган төгрөг) репо хэлцлийн хүрээнд авсан богино хугацаат зээл байсан. Эдгээр зээл нь жилийн 19.0%-иас 20%-ийн хооронд хэлбэлзэх хүүтэй бөгөөд зээлүүдийг 2,200,000 мянган төгрөгийн (2024: 2,000,000 мянган төгрөг) балансаар хэмжигдсэн зээл, авлагаар барьцаалсан.

18 Зээлээр авсан санхүүжилт (Үргэлжлэл)

- iii. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группд гуравдагч этгээдүүдээс авсан 44,823,908 мянган төгрөгийн (2024: 35,723,935 мянган төгрөг) итгэмжлэлийн санхүүжилт байсан бөгөөд хүүгийн төлбөрийг сар бүр, улирал тутам, эсвэл хагас жил тутам хийх нөхцөлтэй, жилийн 9%-аас 21.5%-ийн (2023: 15.0%-23.0%) хүүтэй байв. Эдгээр санхүүжилтийн хугацаа нь 2026 оны 1 дүгээр сарын 3-наас 2027 оны 12 дугаар сарын 14-ний хооронд дуусахаар тогтоогдсон.

Мөн Группд гуравдагч этгээдүүдээс авсан 5,982 мянган ам.долларын (2024: 6,155 мянган ам.доллар) итгэмжлэлийн санхүүжилт байсан бөгөөд хүүгийн төлбөрийг сар бүр, улирал тутам, эсвэл хагас жил тутам хийх нөхцөлтэй, жилийн 9.0%-иас 13.0%-ийн (2024: 9.0%-13.0%) хүүтэй, зээлүүдийн хугацаа нь 2026 оны 1 дүгээр сарын 2-ноос 2027 оны 9 дүгээр сарын 1-ний хооронд дуусахаар тогтоогдсон

19 Бусад өр төлбөр

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Бусад өр төлбөр:		
Компани, хувь хүнд өгөх бусад өр төлбөр	3,124,172	937,346
Бусад өглөг	331,071	500,049
Нийт бусад санхүүгийн өр төлбөр	<u>3,455,243</u>	<u>1,437,395</u>
Бусад санхүүгийн бус өр төлбөр:		
Орлогын албан татвараас бусад татварын өр төлбөр	1,421,751	712,988
Ирээдүйд олгохоор тооцолсон зээлийн хүлээж болзошгүй эрсдэлийн сан	185,031	113,351
Нийт бусад санхүүгийн бус өр төлбөр	<u>1,606,782</u>	<u>826,339</u>
Нийт бусад өр төлбөр	<u><u>5,062,025</u></u>	<u><u>2,263,734</u></u>

Компани, хувь хүнд өгөх бусад өр төлбөрт холбоотой талууддаа төлөх 8,581,504 мянган төгрөг (2024 онд 4,450,405 мянган төг) багтаасан (Тодруулга 25). Хамтран ажиллаж буй талууд болон бусад талуудад төлөх өр төлбөр үлдсэн хэсгийг бүрдүүлж байна.

СТОУС 9 стандартын дагуу, компани ирээдүйд олгохоор тооцсон зээлийн хүлээж болзошгүй эрсдэлийн санг тооцож бүртгэсэн ба зээлийн хүлээж болзошгүй эрсдэлийн сан дараах байдалтай байна:

	2025 Мян.төг	2024 Мян.төг
2025 оны 1 сарын 1-нээр	113,351	72,245
Ирээдүйд олгохоор тооцсон зээлийн үнэ цэнийн зардал (Тод. 6)	71,680	41,106
2025 ны 12 сарын 31-нээр	<u>185,031</u>	<u>113,351</u>

20 Хувьцаат капитал ба бусад нөөц**20.1 Хувьцаат капитал**

Группийн нийт зөвшөөрөгдсөн бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг нь 800,000,000 бөгөөд нэгж хувьцааны үнэ нь 10 төгрөг (2024 онд 10 төг), нэмж төлөгдсөн капиталын хэмжээ нь 2,756,859 мянган төгрөг ба нийт хувьцаат капиталын хэмжээ нь 10,756,859 мянган төгрөг байна. Бүх гаргасан хувьцаа нь бүрэн төлөгдсөн ба нэгж энгийн хувьцаа нь 1 саналын эрхтэй.

Группийн толгой компани нь АНД Системс бөгөөд эцсийн толгой компани Сингапур улсад бүртгэлтэй компани болох АНД Глобал ПиТиИ Лтд.

Хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг доорх хүснэгтэд харуулав:

	2025	2024
АНД Системс	75.0%	75.0%
Олон нийт	17.4%	17.4%
Халаасны хувьцаа	7.6%	7.6%
	<u>100.0%</u>	<u>100.0%</u>

Тайлант жилд Групп хувьцаа эзэмшигчдэдээ 11,089,521 мянган төгрөгийн (2024 он: 5,914,413 мянган төгрөг) ногдол ашиг зарлаж, төлсөн.

20.2 Халаасны хувьцаа

2025 оны 12-р сарын 31-ний байдлаар компаний халаасны хувьцааны тоо ширхэг 60,698,317 ширхэг байсан ба нийт мөнгөн дүн нь 2,337,547 мянган төгрөг байсан (2024: 2,337,547 мянган төгрөг). Эдгээр хувьцаануудыг оролцуулалгүйгээр нийт гаргасан хувьцааны тоо 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр 739,301,683 хувьцаа байсан (2024: 739,301,683 хувьцаа).

20.3 Бусад нөөц

2018 оны 6 дугаар сард Группийн хамгийн дээд түвшний холдинг нэгж болох АНД Глобал Пти Лтд нь Компанийн гол удирдах ажилтнуудад хувьцааны урамшуулал олгосон. Уг хувьцааны урамшуулал нь Групп энэхүү урамшууллыг бэлэн мөнгөөр эсвэл өөр аргаар төлөх үүрэг хүлээгээгүй тул өмчөөр тооцогдох хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээ гэж бүртгэгдсэн. Урамшуулал нь Группд ажиллах хугацааг тасралтгүй хадгалах болон 2018 оны 12 дугаар сарын 31-нд дууссан санхүүгийн жилийн зах зээлийн бус гол гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг биелүүлэх нөхцөлтэй. Нийт бүртгэгдсэн бусад нөөцийн хэмжээ нь 57,348 мянган төгрөг байна (2024: 57,348 мянган төгрөг).

21 Эрсдэлийн удирдлагын тодруулга

21.1 Танилцуулга

Компаний үйл ажиллагаанд тулгамддаг гол эрсдэлүүд нь зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл болон үйл ажиллагааны эрсдэл бөгөөд эдгээрийг компаний гүйцэтгэх захирал хянаж байдаг. Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь бизнесийн сегментүүдэд тэдгээрийн эрсдэл/өгөөжийн түвшинд нийцүүлэн хөрөнгийг хуваарилах, мөн тогтоосон эрсдэлийн хягаар болон хяналтуудын хүрээнд эрсдэлийг тасралтгүй тодорхойлох, хэмжих, хянах үйл явцаар дамжуулан компанийн эрсдэлээр тохируулсан хөрөнгийн өгөөжийг хамгийн өндөр түвшинд хүргэхэд оршино. Энэ эрсдэлийн удирдлагын процесс нь компаний тогтвортой ашигт ажиллагаанд маш чухал бөгөөд компанид ажиллаж буй хүн бүр өөрийн хариуцсан чиг үүрэгтэй холбоотой эрсдэлийн өртөлтийн төлөө хариуцлага хүлээдэг.

Бие даасан эрсдлийн хяналтын үйл явц нь макро орчны өөрчлөлт, технологийн хөгжил, салбарын түвшний бизнесийн эрсдэл зэрэг бизнесийн шинжтэй эрсдлийг хамардаггүй. Эдгээр эрсдлийг Компанийн стратегийн төлөвлөлтийн хүрээнд хянаж үнэлдэг.

Компанийн эрсдэлийн удирдлагын хүрээ нь эрсдэлийг бүрэн арилгах бус, харин эрсдэл ба өгөөжийн харьцааг оновчтой түвшинд барих зорилготой. Тохируулсан эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь дараах зорилтуудыг хангах үүднээс хэрэгждэг:

- (i) Эрсдэлийг удирдаж буй ажилтнууд эрсдэлийн шаардлага, хэмжих тогтолцоог тодорхой, бүрэн ойлгосон байх;
- (ii) Хөрөнгийн хуваарилалт нь эрсдлийн өртөлтийн түвшинтэй нийцсэн байх;
- (iii) Компанийн гүйцэтгэлийн зорилтууд нь компанийн эрсдэлийн дуршилт болон тэсвэрлэх чадвартай уялдсан байх.

21.2 Эрсдэлийн удирдлагын бүтэц

ТУЗ нь группийн нийт эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээг тодорхойлох, эрсдэлийн бодлого болон зээлийн бодлогыг батлах үүрэгтэй бөгөөд эдгээр бодлогууд нь компанийн эрсдэлийн мэдрэмж болон тэсвэрлэх чадварыг тогтоодог. 2018 оны 5 дугаар сарын 10-нд хувьцаа эзэмшигч нь 9 гишүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр томилсон бөгөөд хамгийн сүүлд 2024 оны 3 дугаар сарын 30-нд томилгоо хийгдсэн. 2024 оны 10 дугаар сард Гүйцэтгэх захирал компанийн Эрсдэлийн удирдлагын газрын захирлыг томилсон бөгөөд түүний гол зорилго нь компанийн нийт эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Дотоод аудитын үйл ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо руу шууд тайлагнадаг, хараат бус Дотоод аудитор гүйцэтгэдэг. Мөн тайлант жилд Мэдээллийн технологийн аудитор ажилд томилогдсон

21.3 Зээлийн эрсдэл

Компанийн хяналтаас гадуур үүсэх нөхцөл байдал болон ирээдүйн хөгжлийн талаарх таамгууд өөрчлөгдөж болзошгүй бөгөөд ийм өөрчлөлтүүд гарсан тохиолдолд тэдгээр нь компаний ашигласан таамаглалд тусгагдана. Удирдлагын мэдлэг, мэргэжлийн шүүлт болон тооцоололд ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд санхүүгийн тайланд бүртгэгдсэн дүнгүүдэд, хамгийн өндөр нөлөөтэй зүйлсийг доор дурдсан бөгөөд эдгээр нь холбогдох шүүлт/тооцооллын хамт тусгагдсан.

Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийн хэмжээг тодорхойлохдоо эдийн засгийн тогтворгүй байдлын боломжит нөлөөллийг харгалзан үзсэн бөгөөд энэ нь зах зээлээс ажигдагдах боломжит мэдээлэлд үндэслэсэн удирдлагын хамгийн бодит үнэлгээг илэрхийлж байна. Гэсэн хэдий ч санхүүгийн зах зээл тогтворгүй хэвээр байгаа тул бүртгэгдсэн дүнгүүд нь зах зээлийн хэлбэлзэлд мэдрэмтгий хэвээр байна.

Компанийн хяналтаас гадуур үүсэх нөхцөл байдал болон ирээдүйн хөгжлийн талаарх таамгууд өөрчлөгдөж болзошгүй бөгөөд ийм өөрчлөлтүүд гарсан тохиолдолд тэдгээр нь компаний ашигласан таамаглалд тусгагдана. Удирдлагын мэдлэг, мэргэжлийн шүүлт болон тооцоололд ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд санхүүгийн тайланд бүртгэгдсэн дүнгүүдэд, хамгийн өндөр нөлөөтэй зүйлсийг доор дурдсан бөгөөд эдгээр нь холбогдох шүүлт/тооцооллын хамт тусгагдсан.

21 Эрсдэлийн удирдлагын тодруулга (Үргэлжлэл)**21.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)**

Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийн хэмжээг тодорхойлохдоо эдийн засгийн тогтворгүй байдлын боломжит нөлөөллийг харгалзан үзсэн бөгөөд энэ нь зах зээлээс ажигдагдах боломжит мэдээлэлд үндэслэсэн удирдлагын хамгийн бодит үнэлгээг илэрхийлж байна. Гэсэн хэдий ч санхүүгийн зах зээл тогтворгүй хэвээр байгаа тул бүртгэгдсэн дүнгүүд нь зах зээлийн хэлбэлзэлд мэдрэмтгий хэвээр байна.

Компанийн зээлийн эрсдэлийн гол эх үүсвэр нь зээлийн үйл ажиллагаанаас үүсэх зээлийн алдагдал юм. Зээлийн эрсдэл нь 1) Зээлийн хязгаарын батлах үйл явц болон 2) зээл олгосны дараах зээлийн мөчлөгийн удирдлагаас үүсэж болзошгүй. Зээлийн мөчлөгийн удирдлагаас үүсэж болзошгүй. Зээлийн хязгаар батлах үйл явцаас гарах эрсдэл нь ЛэндМН системийн зээлийн онооны модулийн буруу үнэлгээний улмаас Харилцагчдад тохиромжгүй хэмжээний зээл, тохиромжгүй шимтгэлтэйгээр батлагдсанаас үүдэн бий болдог. Компанийн зээлийн оноо нь машин сургалтын алгоритмд суурилдаг бөгөөд энэ нь компанийн түүхэн зээлийн мэдээлэл, тухайлбал, хугацаа хэтэрсэн төлбөр, өмнөх зээлийн өрийн үлдэгдлийн мэдээлэлд тулгуурлан зээлийн эрсдэлийн үнэлгээний нарийвчлалыг тасралтгүй сайжруулдаг. Гүн сургалтын технологид суурилсан машин сургалтын систем нь илүү олон зээлийн мэдээлэл хуримтлагдах тусам өөрийн алгоритмыг тэр даруй шинэчилж, зээлийн онооны загварыг цаашид ирээдүйн гүйлгээнд тааруулан оновчтой болгох боломжийг бүрдүүлдэг.

Компанийн удирдлага нь зээлийн дүнгийн интервал болон шимтгэлийн түвшинг тогтоодог бөгөөд ЛэндМН систем нь эдгээрийн хүрээнд зээлийн шийдвэрийг автоматаар гаргаж, зээлийн онооны алгоритмаа тасралтгүй шинэчилдэг. Удирдлага нь хугацаа хэтэрсэн зээлийн бүтцийг 1 өдөр, 30 өдөр, 60 өдөр болон 90 өдрөөс дээш хугацаа хэтэрсэн ангиллаар зорилтот хувьтай харьцуулан хянаж байдаг.

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Компанийн зээлийн эрсдэл нь ЛэндМН систем зээлийн шийдвэр гаргасны дараа, тухайн зээл олгогдсон үеэс хойш ч үүсэж болзошгүй. Зээлийн төлбөр хүлээн авалтын алба нь харилцагчдын төлбөрийн зан төлөвт гарч буй хандлагыг илрүүлэх зорилгоор хугацаа хэтэрсэн зээлүүдийг өдөр бүр хянадаг. Зээлийн төлбөр хүлээн авалтын алба нь ЛэндМН системийн хугацаа хэтэрсэн зээлийн мэдэгдлийн модулийн ажиллагааг хамгийн үр ашигтай түвшинд ажиллахыг хангах бөгөөд харилцагчдын төлбөрийн зан төлөвт өөрчлөлт ажиглагдсан тохиолдолд тус модулийг шинэчлэн сайжруулдаг.

Холбоо барих төв нь зээлийн төлбөр хүлээн авалтын албаны шууд хяналтан дор Харилцагчдад төлбөрийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээлэл, зөвлөгөө өгснөөр хураан авалтын үйл ажиллагааг дэмждэг.

Алдагдал үүсэх магадлал. Компани нь зээлдэгч гэрээний төлбөрөө 90 хоногоор хэтрүүлсэн бүх тохиолдолд, мөн бүтцийн өөрчлөлт хийсэн 2-р шатлалын зээлийг оруулаад чанар муудсан зээлүүдийг 3-р шатлал (үнэ цэнэ буурсан) гэж үздэг. Компани банкны үлдэгдэл болон бусад авлагыг тухайн гэрээнд заасны дагуу ажлын өдөр дуусахад шаардлагатай өдрийн төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд чанар муудсан гэж үзэж яаралтай арга хэмжээ авдаг.

Зээлийн төлбөр төлөгдөхгүй байх магадлалын тодорхойлолт гэдэг нь тодорхой хугацааны туршид чанар муудах боломжит нөхцөлийн үнэлгээ. ТТБМ нь тухайн санхүүгийн хэрэгсэл өмнө нь данснаас хасагдаагүй, зээлийн багцад хэвээр байгаа тохиолдолд үнэлэгдэж буй хугацааны тодорхой мөчид үүсч болно

21 Эрсдэлийн удирдлагын тодруулга (Үргэлжлэл)

21.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Урьдчилсан төлөвийн мэдээлэл. ХБЗА-ын загваруудад компани өргөн хүрээний макро эдийн засгийн урьдчилсан төлөвийн мэдээллийг эдийн засгийн өгөгдөл болгон ашигладаг. Үүнд:

- Дотоодын нийт бүтээгдэхүүн,
- Инфляци,
- Зээлийн нийлүүлтийн өсөлт,
- Сар бүрийн M2- мөнгөний нийлүүлэлт,
- Ажилгүйдлийн түвшин,
- Ажилгүйдлийн түвшний өөрчлөлт,
- Сарын дундаж цалин,
- Сарын гадаадын хөрөнгө оруулалтын түвшин

Компанийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн ирээдүйн алдагдлын магадлалыг хамгийн сайн тайлбарлах макро эдийн засгийн хувьсагчийг тодорхойлохын тулд Компанийн зүгээс тухайн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн туршид хуримтлагдсан улирлын ажиглагдсан ТТБМ-ын өгөгдлийг ашиглан шугаман регрессийн шинжилгээ хийсэн. Энэхүү регрессийн шинжилгээ нь сонгосон макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулан тооцогдсон.

ХБЗА чанаргүйдэлд өртөх магадлал гэдэг нь тайлагналын өдрөөс хойш үндсэн болон хүүний төлбөр гэрээнд заасан төлөлт болон бусад, урьдчилан зөвшөөрсөн зээлийн шугамын ашиглалт, мөн хугацаа хоцорсон төлөлтөөс үүсэх хуримтлагдсан хүү зэрэг өртгийн өөрчлөлтүүдийг харгалзан чанар муудалт гарах ирээдүйн өдрөөр тооцоолсон өртгийн хэмжээ.

Регрессийн загварууд нь тоон болон чанарын хяналтын шалгуурыг хангасан бөгөөд 95%-ийн итгэлцлийн түвшинд статистикийн хувьд утга бүхий коэффициенттэй, мөн тохируулсан R-квадратын үзүүлэлт нь 60%-иас өндөр байсан.

Алдагдал үүсэх магадлал. Автомашины зээлийг эс тооцвол, Компанийн зээл болон авлагд хамаарах АҮМ-ыг 2017 оны 3 дугаар сараас 2025 оны 12 дугаар сар хүртэлх түүхэн мэдээлэлд үндэслэн сар бүр дараах томъёогоор тооцоолсон

$$АҮМ = 1 - (90 \text{ хоногоос дээш хугацаанд нөхөн төлөгдсөн дүн} / 90 \text{ хоногоос дээш хугацаатай аливаа зээлийн дүн})$$

Автомашины зээлийн алдагдлын коэффициентийг үнэлэх компаний аргачлал нь бусад бүтээгдэхүүнүүдийнхээс ялгаатай. Учир нь эдгээр зээл нь зээлдэгчийн өмчилдөг автомашинаар барьцаалагдсан байдаг.

Компанийн зүгээс автомашины барьцаатай зээлд анхдагч зөрчил гарсан үед барьцааны тээврийн хэрэгслээс нөхөн төлөгдөх боломжийн түвшин болон барьцааг борлуулснаар бий болох мөнгөн орлогыг харгалзан үздэг. Компанийн зүгээс ирээдүйн бэлэн мөнгөний орлогын өнөөгийн үнэ цэнийг тооцоолж, жинлэсэн дундаж зээлийн алдагдлын коэффициентийн хувь хэмжээг тодорхойлдог. Ирээдүйн мөнгөн орлогыг үнэлэхдээ, удирдлагын баг нь Монголын зах зээл дээр үнэ цэнийг үнэлэхэд мэргэжилтнүүд түгээмэл ашигладаг, хамгийн өргөн хэрэглэгддэг худалдааны цахим сайтуудаас Компанийн зээлийн портфелид харгалзах автомашины зах зээлийн үнийн мэдээллийг цуглуулсан.

Зээлийн хөрвүүлэлтийн хүчин зүйл. Зээлийн хөрвүүлэлтийн хүчин зүйлийг 2025 онд **16.6%** (2024 онд: **32.66%**) гэж тооцоолсон.

21 Эрслэлийн удирдлагын тодруулга (Үргэлжлэл)**21.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)****Үнэ цэнийн бууралтын үнэлгээ (үргэлжлэл)**

ХБЗА загварын үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор Компанийн зүгээс ЧМ, ЧМҮА, ТҮӨ зэрэг бүх өгөгдөл өгөгдлийг гуравдагч этгээдүүд (Монголбанк, Үндэсний статистикийн хороо зэрэг)-ээс авсан баталгаатай макро эдийн засгийн мэдээлэлд тулгуурлан бүрдүүлдэг. Өгөгдөл өгөгдлийн үнэн зөвийг баталгаажуулж, олон хувилбарт суурилсан макро эдийн засгийн нөхцөл байдлын жинг тодорхойлохын зэрэгцээ эдгээр мэдээллийг Компанийн ЭЗА загварт тохируулан нягтлан шалгадаг. ХБЗА-ын тооцооллын суурь бодлого, ашигласан шүүлт, тооцооллын аргачлалыг тайлангийн Тодруулга 2 – Суурь нягтлан бодох бүртгэлийн бодлогууд болон Тодруулга 4 – Нягтлан бодох бүртгэлийн бодлого хэрэглэхтэй холбоотой шүүлт, тооцооллууд хэсгүүдэд дэлгэрэнгүй тусгасан.

Барьцаа болон бусад зээлийн сайжруулалтууд

Автомашины зээлүүд нь зээлдэгчдийн худалдан авсан автомашинаар барьцаалагдсан байдаг. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн автомашины зээлийн портфелид барьцаанд байгаа автомашины зах зээлийн үнэлгээ нь 2,700 сая төгрөг (2024: 6,545 сая төгрөг) байв.

Компани нь олон макро эдийн засгийн хувилбар ашигладаг тул хамгийн сайн боломжит нөхцөл, суурь нөхцөл болон муу нөхцөл хувилбаруудыг тогтмол шинэчилж байдаг. Компанийн зүгээс ЧМҮА болон ТТБМ-ийн эцсийн хувь хэмжээг тооцоолоход хамгийн боломжит нөхцөл, суурь нөхцөл болон муу нөхцөл хувилбаруудад харгалзуулан тус бүрт нь 10%, 70% болон 20%-ийн магадлалын жингүүдийг (2024 онд: 20%, 60% болон 20%) оноосон. Эдгээр хувилбарын магадлалыг тодорхойлохдоо удирдлагын зүгээс эдийн засгийн олон хүчин зүйлсийг харгалзан үзсэн бөгөөд үүнд: ДНБ-ийн өсөлтийн төлөв, тухайн үеийн эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдал, Монгол Улсын уул уурхайн салбарын гүйцэтгэл, мөн Монголбанкны 2026 оны инфляцийн зорилт зэрэг нь эдийн засгийн боломжит нөлөөллийг урьдчилан тооцоход чухал хүчин зүйлүүд гэж үзсэн.

21 Эрсдэлийн удирдлагын тодруулга (Үргэлжлэл)**21.4 Хөрвөх чадварын эрсдэл**

Компани нь хөрвөх чадварын эрсдэлийг удирдахдаа зээл олголтын нэмэгдэж буй хэрэгцээг хангах, мөн өдөр тутмын үйл ажиллагаанаас үүсэх санхүүгийн үүргүүдийг хугацаанд нь биелүүлэхэд шаардлагатай хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгө болон хөрвөх чадвартай эх үүсвэрийг бүрдүүлэн хадгалах зорилготой юм. Зээлийн санхүүжилтийн хэрэгцээг хангахад шаардлагатай эх үүсвэрийг Компани холбогдох талуудаас хувь нийлүүлсэн хөрөнгө болон өрийн санхүүжилт хэлбэрээр, мөн гуравдагч этгээдүүдээс гадаад өрийн санхүүжилт хэлбэрээр татан төвлөрүүлдэг.

Гэрээний үлдсэн хугацаагаар ангилсан санхүүгийн өр төлбөрүүдийн шинжилгээ

Дараах хүснэгтэнд 2025 болон 2024 оны 12 сарын 31-нээрх Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг тэдгээрийн гэрээнд заасан эргэн төлөлт хийх үүрэгт үндэслэн төлөгдөх хугацаагаар нь харуулав.

	Хугацаагүй Мян.төг	3 сараас доош Мян.төг	3-6 сар Мян.төг	6-12 сар Мян.төг	1-5 жил Мян.төг	5-аас дээш жил Мян.төг	Санхүүгийн өр төлбөрийн нийт дүн Мян.төг
2025 оны 12 сарын 31:							
Зээлийн хүлээж болзошгүй эрсдэлийн сан	11,651,871	—	—	—	—	—	11,651,871
Зээлээр авсан санхүүжилт	8,610,658	25,504,616	33,085,554	83,430,783	130,484,188	—	281,115,799
Түрээсийн өр төлбөр	—	253,636	253,636	507,272	2,809,084	—	3,823,628
Бусад өр төлбөр	3,455,243	—	—	—	—	—	3,455,243
	<u>23,717,772</u>	<u>25,758,252</u>	<u>33,339,190</u>	<u>83,938,055</u>	<u>133,293,272</u>	<u>—</u>	<u>300,046,541</u>
2024 оны 12 сарын 31:							
Зээлийн хүлээж болзошгүй эрсдэлийн сан	8,491,805	—	—	—	—	—	8,491,805
Зээлээр авсан санхүүжилт	3,047,239	15,319,264	39,570,647	105,932,858	25,199,673	—	189,069,681
Түрээсийн өр төлбөр	—	232,823	232,823	516,172	4,458,779	—	5,440,597
Бусад өр төлбөр	1,437,395	—	—	—	—	—	1,437,395
	<u>12,976,439</u>	<u>15,552,087</u>	<u>39,803,470</u>	<u>106,449,030</u>	<u>29,658,452</u>	<u>—</u>	<u>204,439,478</u>

Ирээдүйд олгохоор тооцсон зээл ойрын хугацаанд бүрэн ашиглагдахгүй гэж удирдлага үзэж байна.

21 Эрсдэлийн удирдлагын тодруулга (Үргэлжлэл)**21.5 Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл нь хүүний түвшин, валютын ханш зэрэг зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэгслийн бодит үнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдэл юм. Компани энэхүү эрсдэлийн хүчин зүйлийг мэдрэмжийн шинжилгээ ашиглан удирдаж, хянаж ажилладаг.

21.6 Хүүгийн түвшний эрсдэл

Хүүний хувь хэмжээнээс үүсэх эрсдэл нь зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ эсвэл түүний ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэж болзошгүй эрсдэлийг илэрхийлдэг. Компанийн хүүний эрсдэл нь голчлон Харилцагчдад олгосон зээл, авах авлага, мөн өр төлбөрүүдээс үүдэн бий болдог. Компанийн хүүний түвшний өөрчлөлтөд өртөх дүн нь компанийн банк дахь тогтмол хүүтэй харилцах данс, Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, түүнчлэн компанийн өр төлбөрүүдтэй холбоотой байдаг. Тайлант хугацааны байдлаар компанид хувьсах хүүтэй санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр ач холбогдолтой хэмжээгээр байхгүй тул компани хүүгийн түвшнээс үүсэх эрсдэлийг хэмжихийн тулд мэдрэмжийн шинжилгээ одоогоор ашигладаггүй.

21.7 Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн эрсдэл нь валютын ханшийн зөрүүгээс болж санхүүгийн хэрэглүүрийн ирээдүйн мөнгөн урсгалын бодит үнэ цэн хэлбэлзэх эрсдэлийг илэрхийлдэг. Компанийн хувьд гадаад валютын өртөлтийн түвшинд эрсдэлийн хязгаар тогтоож, эдгээр хязгаарыг компанийн баталсан эрсдэлд хандах хандлагад нийцүүлэн тогтмол хяналт тавьдаг.

	2025		2024	
	Хөрөнгө Мян.төг	Өр төлбөр Мян.төг	Хөрөнгө Мян.төг	Өр төлбөр Мян.төг
Гадаад валютаар илэрхийлсэн	8,380,985	116,592,815	1,992,735	32,387,547

Гадаад валютын мэдрэмжийн шинжилгээ. Компанийн голлосон эрсдэл нь АНУ-доллар (USD) болон евро (EUR) валютын ханшийн хэлбэлзлээс үүснэ. Доорх хүснэгт нь гадаад валютын ханш Монгол төгрөгтэй харьцаж 10%-иар өсөх эсвэл буурах тохиолдолд компанийн мэдрэг чанарыг дэлгэрэнгүй харуулж байна. Мэдрэгч шинжилгээ нь зөвхөн гадаад валютын дүнтэй үлдэгдэлтэй мөнгөн хөрөнгийг багтаадаг ба гадаад валютын ханш 10%-иар өөрчлөгдсөн үед улирлын эцэст хөрвүүлэлтийг зохицуулдаг. Энэхүү шинжилгээ нь бусад эрсдэлийн хувьсагчууд тогтмол хэвээр байна гэж үзнэ.

Татварын өмнөх ашигт үзүүлэх нөлөө	Өөрчлөлт	2025 Мян.төг	2024 Мян.төг
Америк Доллар	+/-10%	(10,821,118)/ 10,821,118	(3,039,488)/ 3,039,488
Евро	+/-10%	65/(65)	6,441/(6,441)

21.8 Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл нь мэдээллийн системийн доголдол, хүний алдаа, залилан мэхлэх үйлдэл болон гадаад хүчин зүйлсээс үүдэн хохирол учрах магадлалыг илэрхрийлдэг. Хяналтын процессууд бүрэн хэрэгжихгүй тохиолдолд үйл ажиллагааны доголдол нь компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, эрх зүйн болон зохицуулалтын үр дагавар авчрах, санхүүгийн алдагдалд хүргэх эрсдэлтэй. Компанийн хувьд үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн арилгаж чадахгүй ч давхар хяналтын тогтолцоо, хариуцлагын тусгаарлалт, системд хандах эрхийн хяналт, баталгаажуулалт болон тулгалтын журам, ажилтнуудын сургалт ба үнэлгээ зэрэг арга хэмжээний тусламжтайгаар үйл ажиллагааны эрсдэлийг удирдан, бууруулахыг зорьдог.

22 Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Шүүхийн нэхэмжлэл. Бизнесийн онцлог шинж чанарын улмаас аливаа маргааныг шүүхийн үйл ажиллагааны дагуу шийдвэрлэх нь энгийн үзэгдэл байдаг. Групп нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. 2025 болон 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Групптэй холбоотой ямар нэгэн томоохон шүүхийн хэрэг бүртгэгдээгүй байна.

Татварын хууль тогтоомж. Монгол Улсын татвар, валютын зохицуулалт болон гаалийн хууль тогтоомжийн хэрэглээ зэрэг эдгээр хууль тогтоомж нь тогтмол шинэчлэгдэн өөрчлөгдөж, эрх бүхий байгууллагуудын тодорхойлолт нь цаг хугацааны явцад хэлбэлзэх хандлагатай байдаг. Иймд эдгээр хууль тогтоомжийг компанийн гүйлгээ болон үйл ажиллагаанд хэрэглэн тайлбарласан удирдлагын тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагууд маргаан үүсгэн шалгах, дахин үнэлэх, өөрөөр тайлбарлах боломжтой.

Монгол Улсын татварын байгууллагууд холбогдох хууль тогтоомж болон татварын үнэлгээг тайлбарлахдаа харьцангуй хатуу байр суурь баримтлах хандлагатай байдаг бөгөөд өмнө нь маргаан үүсгэн шалгаагүй гүйлгээ, үйл ажиллагааг ч дахин шалгаж, маргаан дэгдээх боломжтой. Үүний үр дүнд Компанид мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алданги ногдуулах эрсдэл үүсэж болзошгүй юм. Татварын байгууллага нь шалгалт явуулж буй жилийн өмнөх тав хүртэлх календарь жилийн татварын тайлан, баримт бичгийг хянан шалгах эрхтэй бөгөөд тодорхой нөхцөлд энэхүү шалгалтын хугацаа сунгагдаж болзошгүйг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын татварын хууль тогтоомж нь нэмэгдсэн өртгийн албан татвар, суутган төлөгчийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжилт гэх мэт чиглэлүүдэд хангалттай тодорхой зааварчилгаа, зөвлөгөө өгдөггүй юм. Иймд Компанийн зүгээс зарим тохиолдолд эдгээр зохицуулалтыг компанийн нийт татварыг бууруулахуйц байдлаар тайлагнах тохиолдол байдаг. Тиймээс захиргааны байгууллагууд болон шүүхэд сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлт, чиг хандлагаас үүдэн Компанийн дээр дурдсан татварын төрлүүд илүү нарийвчилсан хяналт, шалгалтад өртөх магадлал нэмэгдэж байна. Татварын байгууллагаас маргаан үүсгэн шалгасан тохиолдолд үүсэж болох үр дагаврыг үнэн зөвөөр урьдчилан тооцоолох боломжгүй боловч, ийм үр дагавар нь Компанийн санхүүгийн байдал болон нийт үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжтой.

Удирдлага холбогдох хууль тогтоомжийг өөрийн талаас тайлбарласан байр суурь нь зохистой бөгөөд компанийн татвар болон хууль эрх зүйн байр суурь нь цаашид хадгалагдана гэж үзэж байна. Одоогоор татвар болон хууль эрх зүйн эрсдэл үүсэх магадлалыг бага гэж үнэлж байна. Эдгээр эрсдэлийг тогтмол дахин хянах бөгөөд одоогийн нөхцөл байдалд хангалттай нарийвчлалтай урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд компанийн үнэлгээ цаашид өөрчлөгдөж болзошгүй юм.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл. Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь шаардлагатай бол худалдан авагчдад олгох зээлийн багц бэлэн байгаа эсэхийг баталгаажуулах явдал юм. Зээл олгохтой холбоотой үүрэг нь ЛэндМН шуурхай зээлийн хэлбэрээр зөвшөөрөгдсөн зээлийн шугамын ашиглагдаагүй хэсгийг төлөөлдөг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгах боломжгүй ч зээлийн эрсдэлийг агуулж байгаа тул компанийн нийт эрсдэлийн нэг хэсгийг бүрдүүлдэг. Компани нь ашиглагдаагүй зээлийн нийт үүрэгтэй тэнцэх хэмжээний алдагдалд орж болно. Гэсэн хэдий ч зээлийн хугацааг сунгах ихэнх үүрэг нь үйлчлүүлэгчид зээлийн тодорхой стандартыг баримтлахаас шалтгаалдаг тул учирч болзошгүй алдагдлын хэмжээ нь ашиглагдаагүй нийт үүргээс бага байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар группийн ашиглаагүй зээлийн үүргийн нэрлэсэн нийт үнэ 11,651,871 мян.төг (2024 онд 8,491,805 мян.төг) байна.

23 Капитал удирдлага

Группийн капиталын удирдлагын үндсэн зорилго нь хувьцаа эзэмшигчийг өгөөжтэй, бусад нөлөө бүхий талуудыг үр ашигтай байлгах, капиталын өртгийг бууруулахын тулд капиталын бүтцийг оновчтой түвшинд байлгаж, илүү тохиромжтой байдлаар зохион байгуулан Группийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад оршино. Капиталын бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Групп нь хувь нийлүүлэгчид төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувьцаа эзэмшигчдэд капиталыг буцаан олгох, шинэ хувьцаа гаргах эсвэл өрийг бууруулахын тулд хөрөнгөө худалдаж болно.

Групп нь 2025 онд хөндлөнгөөс тавигдсан бүх шалгууруудыг хангасан.

24 Холбоотой этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээ

Холбоотой этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээ болон данснуудын үлдэгдлийг дор үзүүлэв.

Удирдах түвшний албан тушаалтнуудад олгосон 2024 болон 2025 оны цалин урамшууллыг доорх байдлаар харуулав:

	2025 Мян.төг	2024 Мян.төг
Цалин хөлс	1,711,011	672,490
Эрүүл мэнд болон нийгмийн даатгалын шимтгэл	212,828	83,140
	<u>1,923,839</u>	<u>755,630</u>

Группийн 2025 оны 12 сарын 31 болон 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон онуудад холбоотой талуудтай хийсэн данснуудын үлдэгдлүүдийг дор үзүүлэв.

	Тод.	2025 Мян.төг	2024 Мян.төг
Холбоотой талуудад олгосон зээл – ЛэндМН Систем	(i)	1,516,404	1,838,798
Толгой компаниас авсан зээл (Тод. 18)	(ii)	13,820,236	2,945,393
Холбоотой талаас авсан зээл (Тод. 18)	(ii)	101,799,925	30,057,750
Холбоотой талуудад өгөх өглөг (Тод. 19)	(iii)	1,074,603	350,405
Холбоотой талуудад байгаа хэтэвчний үлдэгдэл	(iv)	-	614,182
Холбоотой талуудаас авах бусад авлага	(iv)	-	-

Компанийн 2025 оны 12 сарын 31 болон 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон онуудад холбоотой талуудтай хийсэн орлогын тайлангийн бүртгэлүүдийг дор үзүүлэв.

		2025 Мян.төг	2024 Мян.төг
Холбоотой талуудын зээлийн хүүгийн орлого – ЛэндМН Систем	(i)	478,500	204,970
Холбоотой талуудаас авсан зээлийн хүүгийн зардал	(ii)	10,900,183	3,936,215
Системийн үйлчилгээний төлбөр (Тод. 7)	(iii)	3,273,031	2,123,539
Холбоотой талуудад үзүүлсэн үйлчилгээний хураамжийн орлого	(v)	76,605	87,045
Интернэтийн төлбөр	(v)	25,200	28,800
Менежментийн үйлчилгээний төлбөр	(v)	720,000	720,000
Хэтэвчний шимтгэл	(vi)	76,605	207,689

24 Холбоотой этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээ (Үргэлжлэл)

- (i) Тайлант хугацаанд Группийн холбоотой талууд болон удирдах албан тушаалтнууд ЛэндМН системээр дамжуулан 1,077,410 Мян.төг (2024 онд 797,329 Мян.төг) зээл авсан бөгөөд үүнээс 759,337 Мян.төг (2024 онд 694,397 Мян.төг) нь эргэн төлөгдсөн байна. Үлдсэн хуримтлагдсан хүүгийн авлага 1,647 Мян.төг (2024 онд 2,871 Мян.төг) байна.

Түүнчлэн ОНДО ХХК нь 2024 онд 1,500,000 Мян.төгрөгийн барьцаат зээл авсан бөгөөд 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 1,260,243 Мян.төг байна.

- (ii) Групп 2021 онд толгой компани АНД Системс ХХК-с хагас жилийн 14% хүүтэй, 5 жилийн хугацаатай, нийт 2,845,000 Мян.төгрөг зээл авсан. (Тод. 17).

- (ii) 2022 оны 12 дугаар сарын 30-нд Групп нь АНД Системс ХХК-с жилийн 18% хүүтэй, 1 жилийн хугацаатай, нийт 10,000,000 Мян.төгрөгийн шугамын зээлийн гэрээ байгуулсан бөгөөд тайлант жилийн эцэст уг зээлийн шугамаас 1,000,000 мянган төгрөгийг татан ашигласан байна. 2023 оны 10 сард энэхүү зээлийн шугамын нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулж, хүүг 19% болгон нэмэгдүүлж, хугацааг 2025 оны 10 дугаар сар хүртэл сунгасан. 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн шугам бүрэн ашиглагдсан байна. 2024 онд Групп зээлийн шугамын дээд хязгаарыг 10,000,000 мянган төгрөгөөс 20,000,000 мянган төгрөг болгон нэмэгдүүлж, хугацааг дахин 1 жилээр шинэчилсэн. 2025 оны 10 сард нөхцөлийг дахин өөрчилж, хугацааг 2026 оны 10 сар хүртэл сунгасан.

2023 оны 10 сарын 20-нд, Групп нь АНД Системс ХХК-с нийт 3,000 мян.ам.долларын шугаман зээлийг, жилийн 12% хүүтэй, 2 жилийн хугацаатай байхаар тохиролцон авсан. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар, энэхүү зээлийн шугамаас 2,970 мян.ам.долларыг татан ашигласан байна.

2025 оны 4 сарын 7-нд, Групп нь дээд түвшний холдинг компани болох АНД ФСЖ Пти.Лтд-тэй нийт 20,000 мян.ам.долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан бөгөөд уг санхүүжилт нь хоёр хэсэгтэй. Эхний 10,000 мян.ам.долларын багц нь 2025 оны 4 сард, хоёр дахь 10,000 мян.ам.долларын багц нь 2025 оны 10 сард тус тус олгогдсон. Эдгээр зээлийн хүү нь SOFR суурьтай хөвөгч хүү бөгөөд эхлэх хүү 15%, доод хүү 14%, дээд хүү 16% бөгөөд хүүг улирал тутамд төлөх нөхцөлтэй. Зээлийн хугацаа 3 жил бөгөөд үндсэн төлбөр нь хувьсагч графикаар хийгдэхээр тусгагдсан. Эдгээр санхүүжилт нь харилцагчид олгосон зээл болон урьдчилгаагаар барьцаалагдсан бөгөөд тайлант өдрийн байдлаар барьцааны дансны үнэ 28,618 мян.ам.доллар байна. Уг санхүүжилтийн бүтэц нь үргэлжилсэн хэлбэртэй бөгөөд үүний дагуу холдинг компани нь Лэндабл Ассет Менежмент ХХК-ээс хөрөнгө татан төвлөрүүлж, түүнийг цааш Компани руу дотоод санхүүжилт хэлбэрээр дамжуулан олгосон болно.

- (iii) 2017 оны 7 сарын 1-нээс эхлэн, Групп нь АНД Системс Тех ХХК-тай ЛэндМН системийн өдөр тутмын засвар үйлчилгээ, дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу АНД Системс Тех ХХК-д төлөх сар бүрийн үйлчилгээний төлбөр нь тухайн сард хийгдсэн зээлийн гүйлгээний тоонд үндэслэн тооцогдож, сар бүр төлөгдөх нөхцөлтэй. Үүнээс гадна, 2018 оны 11 сарын 1-нд, Компани нь АНД Системс Тех ХХК-тэй хэтэвчний системийн засвар үйлчилгээ болон дэмжлэг үзүүлэх нэмэлт гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу үйлчилгээний төлбөр нь зээлийн гүйлгээнээс бусад хэтэвчний гүйлгээний тоонд тулгуурлан тооцогдож, мөн сар бүр төлөгдөх нөхцөлтэй. 2021 онд, Компани нь АНД Сольюшн ПиТиИ, Лтдболон АНД Системс Тех ХХК-тэй ЛэндМН системийн үргэлжилсэн засвар үйлчилгээ, дэмжлэгийн талаар нэмэлт гэрээ байгуулж, уг хугацаанаас эхлэн сар бүрийн засвар үйлчилгээний төлбөрийг АНД Сольюшн ПиТиИ. Лтд-д төлж эхэлсэн.

2025 оны 12 сарын 31-ний байдлаар, холбогдох талуудын өглөгүүдийн үлдэгдэл АНД Сольюшн ПитиИ. Лтд -д үзүүлсэн техник үйлчилгээ болон засвар үйлчилгээ, лицензийн төлбөртэй холбоотой 1,074,602 Мян.төг (2024 онд 319,201 Мян.төг), Супер Ап Хэтэвч ХХК -д төлбөл зохих 2,406,901 Мян.төг (2024 онд 10,309 Мян.төг), ОНДО ХХК -д интернэт үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл болох 13,200 Мян.төг (2024 онд 8,800 Мян.төг), АНД Системс ХХК -д төлбөл зохих дүн тэг (2024 онд 8,523 Мян.төг) байна.

24 Холбоотой этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээ (Үргэлжлэл)

- (iv) Групп нь Супер Ап харилцагчдад зээл олголт, бараа үйлчилгээний худалдан авалт зэрэг зориулалтаар ашиглагдах мөнгийг Супер Ап Хэтэвч ХХК-ийн банкны дансанд байршуулдаг. Супер Ап Хэтэвч ХХК -ийн харьяа дансуудад байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 563,232 Мян.төг (2024 онд 614,182 мян.төг) байна.
- (v) Холбоотой талууд болох ЛэндМН Актив ТЗК ХХК болон Супер Ап Хэтэвч ХХК-д үзүүлсэн үйлчилгээний хөлс 2025 онд тэг төгрөг (2024 онд 187,130 Мян.төг) байна. ОНДО ХХК-аас хүлээн авсан интернэт үйлчилгээний зардал 2025 онд 25,200 Мян.төг (2024 онд 28,800 Мян.төг) болсон. Түүнчлэн Групп нь толгой компани болох АНД Систем ХХК-аас зөвлөх үйлчилгээ хүлээн авдаг бөгөөд 2023 оны 2 сарын 7-нд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, сар бүрийн зөвлөх үйлчилгээний хөлсийг 40,000 мян.төгрөгөөс 60,000 мян.төг болгон нэмэгдүүлсэн.
- (vi) Компани Супер Ап Хэтэвч ХХК-тай 2020 оны 7 сарын 31-ээс эхлэн хэтэвчний төлбөрийн үйлчилгээтэй холбоотой гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу Супер Ап Хэтэвч ХХК-д төлөгдөх хураамжыг тухайн сард хийгдсэн хэтэвчний гүйлгээний тоогоор тогтоож, сар бүр төлдөг.

25 Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ

Дараах хүснэгтэд Группийн хөрөнгө ба өр төлбөрийн эргэн төлөгдөх, эсхүл барагдах хугацаагаар нь ангилсан шинжилгээг харуулсан. Компаний гэрээний дагуу хорогдуулсан эргэн төлөх үүрэг хариуцлагыг Тодруулга 20-оос харна уу.

	12 сараас доош Мян.төг	12 сараас дээш Мян.төг	Нийт Мян.төг
2025 оны 12 сарын 31:			
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	16,315,217	–	16,315,217
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	163,949,128	143,760,753	307,709,881
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	1,339,627	–	1,339,627
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	–	612,210	612,210
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийг хэрэгслүүд	–	33,000	33,000
Бусад хөрөнгө	2,174,883	5,050,457	7,225,340
	<u>183,778,855</u>	<u>149,456,420</u>	<u>333,235,275</u>
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад хөрөнгө	917,077	–	917,077
Орлогын татварын авлага	187,294	–	187,294
Биет бус хөрөнгө	–	1,384,180	1,384,180
Үндсэн хөрөнгө	–	1,984,069	1,984,069
Ашиглах эрхтэй хөрөнгө	–	2,270,617	2,270,617
Хойшлогдсон татварын хөрөнгө	–	202,350	202,350
	<u>1,104,371</u>	<u>5,841,216</u>	<u>6,945,587</u>
Нийт хөрөнгө	<u>184,883,226</u>	<u>155,297,636</u>	<u>340,180,862</u>
Санхүүгийн өр төлбөр			
Бусад өр төлбөр	3,455,243	–	3,455,243
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	–	272,169	272,169
Түрээсийн өр төлбөр	562,321	2,199,450	2,761,771
Зээлээр авсан санхүүжилт	112,959,762	117,156,360	230,116,122
	<u>116,977,326</u>	<u>119,627,979</u>	<u>236,605,305</u>
Санхүүгийн бус өр төлбөр			
Бусад өр төлбөр	1,606,782	–	1,606,782
Хойшлогдсон татварын өр төлбөр	–	138,221	138,221
	<u>1,606,782</u>	<u>138,221</u>	<u>1,745,003</u>
Нийт өр төлбөр	<u>118,584,108</u>	<u>119,766,200</u>	<u>238,350,308</u>
Цэвэр хөрөнгө, өр төлбөр	<u>66,299,118</u>	<u>35,531,436</u>	<u>101,830,554</u>

25 Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ (Үргэлжлэл)

	12 сараас доош Мян.төг	12 сараас дээш Мян.төг	Нийт Мян.төг
2024 оны 12 сарын 31:			
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	12,706,074	–	12,706,074
Бусад хөрөнгө	542,052	–	542,052
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	1,094,548	–	1,094,548
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	129,090,643	102,636,924	231,727,567
	<u>143,433,317</u>	<u>102,636,924</u>	<u>246,070,241</u>
Санхүүгийн бус хөрөнгө			
Урьдчилж төлсөн зардал	391,103	–	391,103
Бусад хөрөнгө	11,000	–	11,000
Биет бус хөрөнгө	–	754,673	754,673
Үндсэн хөрөнгө	–	1,510,130	1,510,130
Ашиглах эрхтэй хөрөнгө	–	3,432,748	3,432,748
Хойшлогдсон татварын хөрөнгө	–	180,977	180,977
	<u>402,103</u>	<u>5,878,528</u>	<u>6,280,631</u>
Нийт хөрөнгө	<u>143,835,420</u>	<u>108,515,452</u>	<u>252,350,872</u>
Санхүүгийн өр төлбөр	1,437,395	–	1,437,395
Бусад өр төлбөр	379,159	3,257,246	3,636,405
Түрээсийн өр төлбөр	143,324,749	26,608,628	169,933,377
Зээлээр авсан санхүүжилт	145,141,303	29,865,874	175,007,177
Санхүүгийн бус өр төлбөр	826,339	–	826,339
Бусад өр төлбөр	3,566,405	–	3,566,405
Орлогын албан татварын өр төлбөр	–	19,776	19,776
Хойшлогдсон татварын өр төлбөр	4,392,744	19,776	4,412,520
	<u>149,534,047</u>	<u>29,885,650</u>	<u>179,419,697</u>
Нийт өр төлбөр	<u>(5,698,627)</u>	<u>78,629,802</u>	<u>72,931,175</u>

26 Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Групп 2026 оны 1 сард Алт инком инвестмэнт ПТИ Лтд. компанитай нийт 5,000 ам.долларын үнийн дүнтэй зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулсан. Энэхүү зээл нь жилд 12%-ийн хүүтэй, хүүг улирал тутамд төлөх, 3 жилийн хугацаатай үндсэн төлбөрийг хугацааны эцэст төлөх нөхцөлтэй. Зээл нь нийт 7,143 мян.ам долларын дүнтэй Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаагаар баталгаажсан.

27 Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувилбарыг баримтална.